




Office for Democratic Institutions and Human Rights

МОНГОЛ УЛС

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ

2013 оны 6-р сарын 26 өдөр

**ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон
Сонгууль Ажиглах Хорооны Эцсийн тайлан**



**Варшав хот
2013 оны 9-р сарын 18 өдөр**

АГУУЛГА

I.	ХУРААНГУЙ	1
II.	ТАНИЛЦУУЛГА БА ТАЛАРХАЛ.....	3
III.	ҮНДЭСЛЭЛ БОЛОН УЛС ТӨРИЙН ОРЧИН	4
IV.	ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА СОНГУУЛИЙН СИСТЕМ	5
V.	СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА	7
A	Санал авах шинэ технологийг ашигласан байдал	9
VI.	СОНГОГЧИЙН БҮРТГЭЛ	10
VII.	НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ	11
VIII.	СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА	12
IX.	СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ САНХҮҮЖИЛТ	16
X.	ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ.....	16
A	Эрх Зүйн Орчин	16
B	хэвлэл мэдээллийн орчин	18
C	ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны хэвлэл мэдээллийн мониторинг	19
XI.	ИРГЭН БА ОЛОН УЛСЫН АЖИГЛАГЧИД.....	20
XII.	ӨРГӨДӨЛ ГОМДОЛ	20
XIII.	САНАЛ АВАХ ӨДӨР	22
A	Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх	23
B	Санал авах байрны нээлт болон санал өгөх.....	23
C	Санал тоолох ба хүснэгтлэх	24
D	сонгуулийн үр дүн, түүнийг зарлах	25
XIV.	ЗӨВЛӨМЖ.....	26
A	нэн тэргүүний зөвлөмжүүд.....	26
B	бусад зөвлөмжүүд	27
	ХАВСРАЛТ – СОНГУУЛИЙН ҮР ДҮН.....	30
	ЕАБХАБ-ЫН АИХЭГ-ЫН ТУХАЙ	32

МОНГОЛ УЛС
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ
2013 оны 6-р сарын 26 өдөр

ЕАБХАБ-ын АИХЭГ-ын Сонгууль Ажиглах хорооны эцсийн тайлан¹

I. ХУРААНГУЙ

ЕАБХАБ-ын Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар (ЕАБХАБ-ын АИХЭГ) нь Монгол Улсын Гадаад харилцааны яамны урилгыг хүлээн авсныхаа дараа Монгол Улсын 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулийг ажиглах зорилго бүхий Сонгууль Ажиглах хороо (САХ)-г 2013 оны 5-р сарын 10-ны өдөр томилов. Монгол Улс 2012 оны 11 дүгээр сарын 21-нд ЕАБХАБ-ын бүрэн эрхт 57 дахь гишүүн орон болсон тул ЕАБХАБ-ын бүх үүрэг амлалтууд, үүний дотор ардчилсан сонгуультай холбоотой амлалтуудыг биелүүлэх үүрэг хүлээсэн. ЕАБХАБ-ын АИХЭГ-ын Монгол Улсад хийсэн анхны сонгуулийн ажиглалт нь 6-р сарын 26 өдрийн Ерөнхийлөгчийн сонгууль байлаа. ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ нь ЕАБХАБ-ын үүрэг амлалтууд болон ардчилсан сонгуулийн төлөөх олон улсын бусад стандарт, түүнчлэн үндэсний хууль, тогтоомж хэрхэн мөрдөгдөж байгааг үнэлсэн.

ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-ноос 2013 оны 6 дугаар сарын 27-нд гаргасан Урьдчилсан үр дүн болон дүгнэлтийн тухай мэдэглэлд 6 дугаар сарын 26-ны өдөр болж өнгөрсөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль нь хуулийн тодорхой хязгаарлалтаас болж хэвлэл мэдээлэлийнхэн сонгогчдод хангалттай мэдээлэл хүргэж чадаагүй хэдий ч эрх чөлөөг хүндэтгэн дээдлэн явагдсан өрсөлдөөнт сонгуулийн сурталчилгаатай байснаараа онцлог байлаа гэж дүгнэсэн. Сонгуулийн санал авах өдөр сонгогчид саналаа чөлөөтэй өгсөн бөгөөд саналаа нууцаар гаргах зарчим байнга хангагдаагүй хэдий ч ажиглалт хийгдсэн сонгуулийн хэсгийн хорооны 99 хувь нь эерэг үнэлгээ авсан.

Энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийг сонгууль болохоос ердөө зургаан сарын өмнө хүчин төгөлдөр болсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай шинэ хууль (2012 оны МҮЕСХ)-ийн дагуу явуулсан. Уг хуулийг боловсруулж баталсан байдал нь сонгуулийн үйл явцад итгэх итгэлийг бууруулсан нь ажиглагдсан. Шинэчилэн найруулсан МҮЕСХ нь өмнөх хуулиасаа сайжирсан ч зохицуулагдаагүй орхигдсон асуудлууд, тодорхойгүй зүйл заалтууд, зарим тохиолдолд хоорондоо зөрчилдсөн заалтууд байгаагаас гадна өргөдөл гомдлыг үр дүнтэй шийдвэрлэх зохицуулалт хангалтгүй байна. Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой техникийн асуудлуудыг Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ) үр дүнтэй удирдан явуулсан боловч сонгуулийн хууль тогтоомжийг жигд, нэгдсэн байдлаар хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг байнга авч хэрэгжүүлсэнгүй.

Бүх шатны сонгуулийн хороо ерөнхийдөө сонгуулийн оролцогч талуудын итгэлийг хүлээсэн. СЕХ нь доод шатны сонгуулийн хорооны ажилд зориулсан иж бүрэн дүрэм журмыг батлаагүйгээс гадна үйл ажиллагаа нь байнга ил тод, нээлттэй байсангүй. Мөн хурлын зараа өөрийн цахим хуудсаараа зарлаагүй ба гаргасан шийдвэрээ олон нийтэд оройтож хүргэж байв.

Бүх шатны сонгуулийн хорооны гишүүдийг төрийн албан хаагчдын дундаас сонгосон. Сонгуулийн хороонуудад төрийн албан хаагчийг ямар шалгуураар сонгон ажиллуулах тухай хуулинд тодорхой тусгаагүй ба ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны урт

¹ Энэхүү тайлангийн Англи хэл дээрх хувилбар нь зөвхөн албан ёсны баримт бичиг болно. Албан бус орчуулгыг Монгол хэл дээр авах боломжтой.

хугацааны зарим ажиглагчид (УХА-чид) тайландаа сонгуулийн бүх шатны хэсгийн хороо, үүний дотор удирдах албан тушаалуудад Ардчилсан Нам (АН)-тай холбоотой төрийн албан хаагчид томилогдсон тухай баттай мэдээллүүдийг дурдсан.

Монгол Улсын сонгогчийн бүртгэл нь идэвхгүй, давтамжтай байдаг бөгөөд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын сангийн мэдээлэлд үндэслэгддэг. Уулзаж ярилцсан улс төрийн намуудын хүмүүс ерөнхийдөө сонгогчийн бүртгэлийн системд итгэлтэй байгаагаар илэрхийлсэн. Гэвч сонгогчдын нэрийн жагсаалтын үйл ажиллагаанд оролцож байгаа эрх бүхий байгууллагуудын уялдаа муугаас болж сонгогчдын нэрийн жагсаалтын чанарт сөргөөр нөлөөлсөн. Нэрийн жагсаалтыг зарим нэг Сонгуулийн хэсгийн хороо (СХХ)-ны санал авах байранд нийтэд зориулан ил тавиагүй байсан ч ерөнхийдөө сонгогчийн хүсэлтээр гаргаж өгөх боломжтой байв.

Ерөнхийлөгчийн сонгуульд гурван нэр дэвшигч өрсөлдсөн. Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавих зарим шаардлагууд нь хэтэрхий хязгаарлагдмал бөгөөд ЕАБХАБ-ын үүрэг амлалт болон ардчилсан сонгуулийн төлөөх олон улсын бусад стандартуудтай нийцэхгүй байна. Жишээлбэл Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, эцэг эх хоёул Монгол Улсын харъяат болохыг баталж чадах Монгол улсын уугуул иргэн байх ёстой. Үүнээс гадна Үндсэн хууль болон МУЕСХ-иар парламент дахь улс төрийн нам, эвслийн Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх эрхэнд хязгаар тавьсан. Мөн Ерөнхийлөгчийн сонгуульд хувь хүн бие даан нэр дэвших боломжгүй байгаа нь 1990 оны ЕАБХАБ-ын Копенгагены баримт бичгийн 7.5 дахь хэсэгтэй зөрчилдөж байна.

Сонгуулийн сурталчилгааны орчин өрсөлдөөнтэй, эвлэлдэн нэгдэх, цуглаан, хөдөлгөөн хийх үндсэн эрх, эрх чөлөөнд хүндэтгэлтэй хандсан байдалтай байлаа. Өрсөлдөгчид сонгуулийн сурталчилгаагаар саад тотгоргүй явуулсан бөгөөд тэдний зохион байгуулсан цуглааны үеэр ямар нэг осол зөрчил гараагүй болно. Зарим улс төрийн намууд санал тоолох автомат төхөөрөмж (СТАТ)-ний найдвартай ажиллагаанд эргэлзэж байгаагаар илэрхийлсэн нь сонгуулийн сурталчилгааны үед асуудал болж байлаа. Гурван нэр дэвшигч гурвуулаа МУЕСХ-ийг зөрчин санхүүгийн чанартай амлалтууд өгсөн. Сонгуулийн сурталчилгаа сүүлийн шатуудад нэлээн идэвхжиж ирсэн боловч нэр дэвшигчид, эсхүл тэдний төлөөлөгчдийн дунд идэвхтэй мэтгэлцээн дутмаг байв.

Сонгуулийн сурталчилгааны санхүүжилт, үүний дотор сонгуулийн дараа санхүүгийн тайланг хэрхэн гаргах нарийвчилсан шаардлагуудын тухай журмыг МУЕСХ-иар тогтоосон. Сонгуулийн үед тайлан гаргах шаардлага хуулинд байхгүй ба СЕХ-нд улс төрийн намуудын санхүүжилтыг хариуцах ажилтан хязгаартай тул сонгуулийн дараа улс төрийн намуудаас ирсэн тайланд аудитын шалгалт хийхийг төлөвлөөгүй. Эдгээр хүчин зүйлс нь МУЕСХ-нд оруулсан хяналтын механизмын үр нөлөөг бууруулах магадлалтай ба сонгуулийн сурталчилгааг санхүүжүүлсэн байдалд итгэх олон нийтийн итгэл буурах талтай.

Ерөнхийдөө үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх зүйн боломж хангагдсан. Гэсэн хэдий ч гүтгэн доромжилсон хэргээр эрүү үүсгэх, интернэт ашиглагчийн санал сэтгэгдлийн агуулгыг зохицуулах тухай тогтоол гарсан явдлыг анхаарах л асуудал юм. Хэвлэл мэдээллийн зах зээл улс төрийн олон ургалч үзлийг тодорхой түвшинд зөвшөөрдөг ба энэ байдлаас болж маш олон тооны хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь улс төрийн тоглогчдын шууд болон шууд бус эзэмшилд байдаг ба мэдээний хөтөлбөрийн агуулгад эзэмшигч хөндлөнгөөс нөлөөлдөг. Энэ нь редакцийн бие даасан хараат бус байдлыг устгадаг. Өргөн нэвтрүүлгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр төлбөртэй болон төлбөргүй явуулах улс төрийн сурталчилгаатай холбоотой хуулийн заалтуудыг ихэнхдээ мөрдөж байсан. Гэсэн хэдий ч мэдээ болон сүүлийн үеийн үйл явдлын тухай хөтөлбөрүүдээр сонгуулийн сурталчилгаа ихээхэн хязгаартай

гаржээ. Энэ байдалд сонгуулийн тухай мэдээ мэдээллийг хэт хязгаарласан эрх зүйн орчин бас нөлөөлсөн. Цаашлаад нэр дэвшигчид хоорондоо мэтгэлцэх, мөн нэр дэвшигчдээс асуулт асуух боломж сэтгүүлчид, шинжээчид болон олон нийтэд олгосон хөтөлбөрүүд бараг байсангүй. Энэ байдал нь хэвлэл мэдээллийнхэн өөрсдийн чиг үүргээ биелүүлэн сонгуулийн асуудлаар болон улс төрийн сонголтуудын талаар ул суурьтай, хүчтэй олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх боломжийг олгосонгүй.

МУЕСХ-ийн дагуу дотоодын болон олон улсын ажиглалт хийхийг зөвшөөрдөг ч сонгуулийн явцыг бүхэлд ажиглах боломжоор илт хангаагүй. Иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийн санал авах өдрөөс өмнөх үеийг ажиглаагүй юм. Энэ нь нэг талаар санхүүгийн боломжгүй байдал, нөгөө талаас сонгуулийн санал авах өдрөөс өмнөх хугацаанд мониторинг хийхийг хязгаарласан СЕХ-ны шийдвэртэй холбоотой. Сонгуулийн санал авах өдөр ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны хийсэн ажиглалтаас харахад бараг бүх хэсгийн хороод дээр нэр дэвшигчдийн төлөөлөл байсан бол харин ажиглалт хийж байгаа иргэний тоо хязгаарлагдмал байлаа.

МУЕСХ-нд хариуцлагын нэг шатлалын бүтэцтэйгээр өргөдөл, гомдол шийдвэрлэх үйл ажиллагааг нарийн тодорхой тусгаж өгөөгүй. Үүний оронд сонгуультай холбоотой өргөдөл гомдлыг хэд хэдэн төрийн тусгай байгууллагууд, шүүхүүдийн харъяаллаар хянаж шийдвэрлэхээр заажээ. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх үйл явцын талаар оролцогч талуудын дунд ойлголцол муу, дагаж мөрдөх хууль тогтоомжийн тайлбар жигд бус байна. Мөн шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх хугацаа нь удаан үргэлжлэх боломжтой байгаа нь ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагены баримт бичгийн 5.10-т заасан шаардлагыг хангахгүй байна. Харамсалтай нь ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ хувьд СЕХ болон цагдаагийн байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдолтой танилцах боломж хязгаарлагдмал байлаа.

Сонгуулийн санал авах өдөр амгалан тайван болж өнгөрсөн ба СЕХ-ны мэдээлснээр сонгуулийн ирц 66.5 хувьтай байлаа. Хэдийгээр сонгогч нууцаар саналаа гаргах боломж байнга хангагдаагүй ч ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ ажиглагчид 6 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх ажиллагаа, санал авах байрнуудын нээлт, санал авах өдрийн санал хураалтын явцыг нэлэнхүйд нь эерэгээр үнэлсэн. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ ажиглагчид процедурын зарим нэг алдааг тэмдэглэсэн хэдий ч санал тоололт бүхэлдээ сайн явагдсан гэж үнэлсэн. Программын алдаанаас болж санал тоолох автомат төхөөрөмжүүд (СТАТ) хүчингүй болсон саналын хуудсыг буруу тооцох тохиолдол гарсан. Сум, дүүргийн сонгуулийн хорооны (СДСХ) тооллогын хүснэгт гаргах үйл явц бүхэлдээ журмын дагуу явагдсан ч зохион байгуулалт болон ил тод байдал хангалтгүй байсныг ажиглагчид тэмдэглэсэн. Наад зах нь сонгуулийн хороонуудын ажлыг зохицуулах дүрэм журам дутмаг зэргээс болж холбогдох журмын хэрэгжилт сонгуулийн өдөр харилцан адилгүй байх тохиолдол гарч байлаа. СЕХ нь Ерөнхийлөгчийн сонгуулийн урьдчилсан дүнг 6 дугаар сарын 27-нд, эцсийн дүнг 7 дугаар сарын 4-ний өдөр тус тус гаргасан хэдий ч сонгуулийн хэсгийн хорооны (СХХ) түвшинд бус зөвхөн аймаг, нийслэлийн түвшинд гаргасан.

II. ТАНИЛЦУУЛГА БА ТАЛАРХАЛ

Монгол Улсын Гадаад харилцааны яамны урилга болон 2013 оны 3 дугаар сарын 4-8-ны хооронд явуулсан Хороо байгуулах хэрэгцээг үнэлэх судалгааны зөвлөмжийг үндэслэн 6 дугаар сарын 26 өдрийн Ерөнхийлөгчийн сонгуулийг ажиглах ЕАБХАБ-ын Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар (ЕАБХАБ-ын АИХЭГ)-ын Сонгууль Ажиглах хороо (САХ)-г

5 дугаар сарын 10 өдөр томилов. ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-г Элчин сайд Одри Гловер удирдаж байсан ба Улаанбаатар хот болон орон даяар 9 газарт ажиллах 14 шинжээч, 24 урт хугацааны ажиглагч (УХА-чид)-аас бүрдэж байсан. ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ нь Сонгуулийн санал авах өдрийг ажиглах ЕАБХАБ-ын бүрэн эрхт гишүүн 33 орны 210 ажиглагчийг томилов.

Монгол Улс 2012 оны 11 дүгээр сарын 21-нд ЕАБХАБ-ын бүрэн эрхт 57 дахь гишүүн орон болсон тул ЕАБХАБ-ын бүх амлалт үүний дотор ардчилсан сонгуультай холбоотой амлалтуудыг биелүүлэх үүрэг хүлээсэн. ЕАБХАБ-ын Монгол Улсад хийсэн анхны сонгуулийн ажиглалт нь 6 дугаар сарын 26 өдрийн Ерөнхийлөгчийн сонгууль байлаа. ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ нь сонгуулийн явц ЕАБХАБ-ын үүрэг амлалт, ардчилалын төлөөх олон улсын бусад стандарт болон үндэсний хууль, тогтоомжийн сахин мөрдөлтийг үнэлсэн. Энэхүү эцсийн тайлан нь 2013 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Хэвлэлийн хурал зарлан олон нийтэд мэдээлсэн Урьдчилсан үр дүн болон дүгнэлтийн тухай мэдэгдлийг дагалдан гарч байна.²

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг ажиглах урилга өгөхийн зэрэгцээ дэмжиж туслан хамтран ажилласан Монгол Улсын Гадаад харилцааны яам болон итгэмжлэл олгон хамтран ажилласан Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ)-нд талархлаа илэрхийлье. Түүнчлэн хамтран ажилласан төв, орон нутгийн байгууллагууд, сонгуулийн байгууллагууд, нэр дэвшигчид, улс төрийн намууд болон иргэний нийгмийн байгууллагуудад, түүгээр зогзохгүй дэмжлэг туслалцаа үзүүлсэн Монгол Улсад суугаа ЕАБХАБ-ын гишүүн орнуудын Элчин сайдын яамд болон хамтран ажилласан бусад олон улсын байгууллагуудад мөн талархсанаа илэрхийлж байна.

Ш. ҮНДЭСЛЭЛ БОЛОН УЛС ТӨРИЙН ОРЧИН

Үндсэн хуулийн заалттай уялдуулан Монгол Улсын Их Хурал (парламент) Ерөнхийлөгчийн сонгуулийг 2013 оны 6 дугаар сарын 26-ны өдөр товлон зарласан. 2012 оны 7 дугаар сард явагдсан Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнд парламент дахь 76 суудлын 34 суудлыг Ардчилсан Нам (Ерөнхий сайд Норовын Алтанхуягын удирдсан АН), 11 суудлыг Шударга ёс эвсэл (Ерөнхийлөгч асан Намбарын Энхбаярын удирдсан),³ 2 суудлыг Иргэний Зориг-Ногоон Нам (УИХ-ын гишүүн, Байгаль орчин, Ногоон хөгжлийн сайд Санжаасүрэнгийн Оюуны удирдсан ИЗНН) авсан ба эдгээр намууд эвслийн засгийн газрыг бүрдүүлсэн. Монгол Ардын Нам (МАН) 26 суудал авч сөрөг хүчин болсон.⁴ 2009 оны 5 дугаар сарын 24-ны өдөр явагдсан Ерөнхийлөгчийн сонгуульд АН-аас нэр дэвшигч Цахиагийн Элбэгдорж 51.2 хувийн санал авч Ерөнхийлөгч асан Н. Энхбаярыг ялжээ.

² ЕАБХАБ-ын АИХЭГ-аас гаргасан Монгол Улсад явагдсан сонгуулийн тайланг www.osce.org/odihr/elections/103142 сайтаас авч танилцах боломжтой.

³ Шударга ёс эвслийг Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН) болон Монголын Үндэсний Ардчилсан Нам (МУАН) бүрдүүлдэг. Н. Энхбаярыг авлигын хэргээр 2012 оны 4-р сард Авлигатай тэмцэх газар баривчилсан ба 2012 оны 8-р сард дөрвөн жил хоригдох ял оноосон. МАХН-ын зүгээс 2012 оны 12-р сард Н. Энхбаярыг хорихын эмнэлэгт эмчлэхийг эсэргүүцэн эвслээс гарна хэмээн сүрдүүлсэн бөгөөд үүний дараа түүнийг эмнэлэгт шилжүүлсэн.

⁴ Мөн гурван гишүүн бие даан нэр дэвшигч Парламентад сонгогдсон. Монголын улс төрд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага хэвээр байна. Одоогийн парламентийн 76 гишүүдийн арван нэг нь (14 орчим хувь), Засгийн газрын 16 сайдын 3 нь эмэгтэй гишүүн байна. Эмэгтэйчүүдийн одоогийн энэ төлөөлөл ЕАБХАБ-ын дундаж болох 24.4 хувиас нэлээн доогуур байна; Нэгтгэсэн тоог Олон улсын парламентын холбооны “Парламент дахь эмэгтэйчүүд” мэдээллийн сангаас үзнэ үү <http://www.ipu.org/wmn-e/world.htm>.

2013 оны Ерөнхийлөгчийн сонгуульд АН-аас нэр дэвшсэн Ц. Элбэгдоржийг парламентад суудалтай бусад хоёр нам болох ИЗНН болон МҮАН, түүнчлэн парламентад суудалгүй Эх Орон Нам, Бүгд Найрамдах Нам болон олны танил тамирчид⁵ дэмжсэн болно. МАН-ын хувьд 5 дугаар сарын 20-ны өдөр парламентад суудалгүй гурван намтай⁶ хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан.

IV. ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА СОНГУУЛИЙН СИСТЕМ

Ерөнхийлөгчийг нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах зарчмаар дөрвөн жилийн хугацаагаар сонгодог. Ерөнхийлөгчид нэр дэвшигч анхны санал хураалтаар сонгогдохын тулд анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн саналыг авах ёстой. Ингэж чадаагүй нөхцөлд хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийн хооронд хоёр дахь санал хураалтыг 14 хоногийн дотор явуулна. Хэрэв хоёр дахь санал хураалтаар Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү олонхи санал аваагүй бол дахин сонгууль явуулна. Сонгуулийг хүчинтэйд тооцохын тулд сонгуулийн хэсгийн хороонд бүртгэлтэй сонгогчдын 50-иас багагүй хувь ирж саналаа өгөх ёстой. Ирц хүрээгүй тохиолдолд СЕХ тухайн ирц хүрээгүй сонгуулийн хэсгийн хороонд сонгуульд оролцох эрхтэй ч, санал өгөөгүй сонгогчдоос нэмэлт санал авах талаар шийдвэр гарган, тухайн шийдвэр гарснаас долоо хоногийн дотор нэмэлт санал хураалтыг зохион байгуулна. Нэмэлт санал хураалтаар авсан саналыг өмнөх саналын тоон дээр нэмэх ба эдгээрийн нэгдсэн дүнг ирцийн эцсийн дүн 50 хувь хүрсэн ч, хүрээгүй ч эцсийн дүн болгон авч үзнэ.

Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, эсвэл хорих газар ял эдэлж байгаа эрх зүйн чадамжгүй иргэдээс бусад сонгуулийн санал авах өдөр 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэд сонгуульд саналаа өгөх эрхтэй. Хорих газар ял эдэлж байгаа иргэдийн үйлдсэн гэмт хэргийн хүнд, хөнгөнийг үл харгалзан сонгуульд санал өгөх эрхийг нь хасч байгаа нь бүх нийтийн сонгуулийн эрх, нэр дэвшүүлэх эрхийн баталгааг сулруулж байгаа ба ЕАБХАБ-ын үүрэг амлалт, олон улсын стандарттай нийцэхгүй байна.⁷

Үйлдсэн гэмт хэргийнх нь хүнд хөнгөнөөс үл хамааран хорих газар ял эдэлж байгаа иргэний сонгуульд оролцох эрхийг хязгаарлаж байгааг оногдуулсан хязгаарлалт болон хэргийн хүнд хөнгөний хоорондын тэнцүү чанарыг хангах үүднээс дахин авч үзэх нь зүйтэй.

Энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийн эрх зүйн орчин нь 1992 оны Үндсэн хууль (1999 болон 2001 онуудад нэмэлт өөрчлөлт орсон), Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль (2012 оны МУЕСХ), Монгол Улсын Сонгуулийн төв байгууллагын тухай хууль

⁵ Тэдний дотор АН-ын гишүүний үнэмлэхээ хүлээн авсаныхаа дараа нэр дэвшигч ерөнхийлөгч Ц. Элбэгдоржийг дэмжихээ олон нийтэд зарласан Долгорсүрэнгийн Дагвадорж (сумогийн бөх), Агваансамдангийн Сүхбат (үндэсний бөх) нар багтана.

⁶ Эх Орончдын Нэгдсэн Нам, Ногоон Нам, Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам.

⁷ Олон улсын стандартын дагуу “Гэмт хэрэгт холбогдсоны улмаас сонгох эрхийг нь түтгэлзүүлбэл оноосон ялын хугацаатай ижил хугацаанд түтгэлзүүлнэ”. НҮБ-ын Хүний эрхийн Хорооноос 1996 онд гаргасан Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын хэлэлцээр (ИУТЭОУХ)-ийн 25 дугаарын Ерөнхий тайлбарын 25-р зүйлийн 14-р хэсгийг үзнэ үү. “Ардчилсан нийгэмд эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа хязгаарлалтыг холбогдох хуулийн зорилтуудын нэгтэй холбох мөн тэрхүү хуулийн зорилготой хатуу нийцэх ёстой” гэж заасан 1990 оны ЕАБХАБ-ын Копенгагены баримт бичгийн 24-р хэсгийг бас үзнэ үү. Европын Хүний эрхийн шүүхийн 2012 оны 5-р сарын 22-ны *Scoppola v. Italy* (No. 3) [Дээд танхим], № 126/05, 2005 оны 10-р сарын 6-ны *Hirst v. The United Kingdom* (No.2) [Дээд танхим], № 74025/01 тоот шийдвэрүүдийг үзнэ үү.

(2006) болон шүүхийн тогтолцоог зохицуулах хуулиудаас бүрдэж байна.⁸ Сүүлийн үед шинэчлэгдсэн хууль тогтоомжийн өөрчлөлтүүдэд жендэрийн тэгш байдлын тухай дэвшилтэт хууль тогтоомж⁹ болон шүүхийн шинэтгэлийн тухай багц хууль¹⁰ багтаж байна. Гэсэн хэдий ч эрх зүйн орчин нь цөөнх болон эмзэг бүлгийнхнийг үр дүнтэй хамгаалахгүй байна.¹¹ Энэ удаагийн сонгууль нь өмнөх хуулиасаа сайжирсан шинэ МУЕСХ-ийн дагуу явагдсан анхны сонгууль юм. Гэсэн хэдий ч шинэ хуулинд орхигдсон асуудлууд, тодорхойгүй зүйл заалтууд олон байна. Жишээлбэл асуудалтай сонгуулийн үр дүн эсвэл нэмэлт санал хураалт явагдаж байхад хоёр дахь санал хураалт явагдвал хэрхэх талаар зохицуулах заалтууд алга байна. Монгол Улсын сонгуулийн нэгдсэн хууль, Улс төрийн намын тухай, Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулиудын төслийг боловсруулах, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг судлах үүрэг бүхий гурван ажлын хэсгийг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дэргэд байгуулсан тухай ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-нд мэдээлсэн.

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомжийг саяхан сайжруулсан хэдий ч зохицуулагдаагүй орхигдсон, хуулинд нийцэхгүй байгаа зүйлүүд байгаа тул үүнийг залруулах мөн ЕАБХАБ-ын үүрэг амлалт, ардчилсан сонгуулийн төлөөх олон улсын стандартуудыг дагаж мөрдөх үүднээс цаашид уг хуулийг хянаж үзэх.

МУЕСХ нь сонгууль эхлэхээс зургаахан сарын өмнө хүчин төгөлдөр болсон ба энэ нь олон улсын сайн туршлагатай уялдахгүй байна.¹² ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-той уулзсан хүмүүс МУЕСХ-ийг олон нийтээр хэлэлцүүлэлгүйгээр яаруу боловсруулж баталсан нь сонгуулийн үйл явцад итгэх итгэлийг бууруулсан хэмээн тэмдэглэж байв. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны ажиглалтаар уг хуулийн дутагдалтай байдал нь хуулийг нэг мөр тайлбарлах болон хэрэглэхэд нөлөөлж байв. Тухайлбал сонгуулийн хорооны гишүүдийн томилгоо, сонгуулийн маргааныг шийдвэрлэх зэргийг дурдаж болно.

Сонгуулийн хууль тогтоомжтой холбоотой аливаа хянан нягтлалтыг хийхдээ бүрэн хамарсан болон нэлтэй аргаар холбогдох бүх оролцогч талуудын, үүний дотор улс төрийн нам, иргэний нийгмийн төлөөллийг багтаасан өргөн оролцоотойгоор хийх.

⁸ Монгол Улс 1974 оны 11-р сарын 18-ны өдрийн ИУТЭОУХ-ийн Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (ЭАУК)-д 1981 оны 7-р сарын 20-ны өдөр нэгдэн орсон ба Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай олон улсын конвенц (ХБИЭК)-д 2009 оны 5-р сарын 13-нд нэгдсэн.

⁹ Жишээлбэл, Жендэрийн Үндэсний хорооны ивээл дор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг 2011 онд, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх стратеги үйл ажиллагааны төлөвлөгөөг 2013 онд тус тус баталсан. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулинд 2012 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр хувь тэнцүүлсэн төлөөллөөр сонгогдсон 28 суудалд жендэрийн 20 хувийн квотыг оруулсан. Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-нд хэлсэнээр эмэгтэйчүүдийн хүчирхэг бүлгүүд илүү үр дүнтэй квотын шаардлагуудын талаар хэлэлцэж мөн энэ ажлыг хөхиүлэн дэмжсээр байна.

¹⁰ Шүүхийн тухай багц хуулийг 2013 оны эхээр баталсан ба 2013 оны 11 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болно.

¹¹ НҮБ-ын олон улсын гэрээний хэрэгжилтийг хангах хороод, Хүний эрхийн тогтмол дүгнэлтээс гарсан зөвлөмжүүдийг дараах холбоосоос харна уу.

<http://www.ohchr.org/EN/countries/AsiaRegion/Pages/MNIndex.aspx>

¹² Олон улсын сайн туршлагаар сонгууль болохоос нэг жилээс доошгүй хугацаанд сонгуулийн хуулийн үндсэн элементүүдэд өөрчлөлт оруулах нь зохимжгүй гэж үздэг. Европын зөвлөлийн хуулиар ардчилал тогтоох Европын комисс (Венецийн комисс)-ын Сонгуулийн асуудлаарх сайн туршлагын дүрмийн II.2b заалт [http://www.venice.coe.int/webforms/documents/CDL-EL\(2002\)005-e.aspx](http://www.venice.coe.int/webforms/documents/CDL-EL(2002)005-e.aspx) -аас үзнэ үү.

V. СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА

Ерөнхийлөгчийн сонгуулийг улсын хэмжээнд СЕХ, аймаг нийслэлийн 22 сонгуулийн хороо (АНСХ буюу 21 аймаг болон нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд), сум, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 339 сум, дүүргийн сонгуулийн хороо (СДСХ), хэсэгт 1,896 сонгуулийн хэсгийн хороо (СХХ) гэсэн дөрвөн шатлалаар зохион байгуулж явуулна. Зургаан жилийн хугацаатайгаар Улсын Их Хурлаас томилогддог есөн гишүүнтэй СЕХ нь байнгын ажиллагаатай ганц сонгуулийн байгууллага юм.¹³ Одоогийн СЕХ-ны хоёр гишүүн нь эмэгтэй юм. АНСХ нь есөн гишүүнтэй (нийслэлд долоон гишүүн), харин СДСХ, СХХ тус бүр долоон гишүүнтэй. АНСХ-ны гишүүдийг СЕХ томилдог бол СДСХ, СХХ-ны гишүүдийг холбогдох АНСХ томилдог. Бүх доод шатны сонгуулийн хороодыг хуульд заасан хугацааны дотор бүрдүүлсэн ба эмэгтэй гишүүдийн тоо эрэгтэй гишүүдээс илүү байна.

Бүх шатны сонгуулийн хороодын гишүүдийг төрийн албан хаагчдын дундаас сонгосон. Сонгуулийн хороодод Төрийн албан хаагчийг ямар шалгуураар сонгон ажиллуулах тухай хуулинд тусгаагүй байгаа бөгөөд сонгуулийн хороодын бүрэлдэхүүний талаар бичгээр үйлдсэн дүрэм журам, заавар байхгүй байна. СЕХ энэ талаар ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-нд мэдээлэхдээ хэдийгээр бичгээр гаргасан зохицуулах журам байхгүй ч сонгуулийн хороонд ажиллуулахаар сонгон дэвшүүлэхдээ тухайн албан хаагчийн туршлага, ‘нэр хүнд’-ийг харгалздаг гэсэн. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны урт хугацааны зарим ажиглагчид (УХА-чид) тайландаа сонгуулийн бүх шатны хэсгийн хороо, үүний дотор удирдах албан тушаалуудад АН-тай холбоотой төрийн албан хаагчид томилогдсон тухай баттай мэдээллүүдийг дурдсан.¹⁴

Сонгуулийн байгууллагад итгэх итгэлийг хадгалах үүднээс МУЕСХ болон СЕХ-ноос гаргасан дүрэм журамд сонгуулийн хорооны гишүүнд нэр дэвших төрийн албан хаагчид тавих шалгуурыг улам нарийвчлан тусгах нь зүйтэй.

Бүх шатны сонгуулийн хороод сонгуулийн үйл ажиллагааны техникийн шинжтэй асуудлуудыг үр дүнтэй мөн хуулийн хугацаанд удирдсан бөгөөд ерөнхийдөө сонгуулийн оролцогч талуудын итгэлийг хүлээсэн. СЕХ оны эхнээс хойш сонгуулийн эцсийн үр дүнг батлагдах хүртэл хугацаанд 14 удаа хуралдсан. Гэсэн хэдий ч СЕХ-ны үйл ажиллагаа нь байнга ил тод, нээлттэй байсангүй. Энэ байдал нь олон улсын сайн туршлагаас зөрүүтэй байна.¹⁵ СЕХ хурлын тухай зараа цахим хуудсан дээрээ тавиагүй төдийгүй хурлын тэмдэглэлүүдээ байрлуулаагүй бөгөөд гаргасан шийдвэрүүдээ цахим хуудасныхаа “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт байрлуулдаг ба шийдвэрүүдээ оройтож нийтлэж байсан¹⁶ ба огноогүйгээр зөвхөн дугаарладаг тул тусгай хуралтай холбогдохгүй байгаа төдийгүй ил тод байдлыг бууруулж байна. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ ажиллаж байх хугацаанд СЕХ-ноос наад зах нь дөрвөн удаа зохион байгуулсан хурлын зөвхөн нэгнийх нь тухай мэдээллийг ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ авч оролцох урилга авсан.

¹³ Зөвхөн СЕХ-ны дарга, нарийн бичгийн дарга нар сонгуулийн орон тооны гишүүн ба бусад долоон гишүүн нь орон тооны бус ба сонгуулийн хугацааны үед үндсэн ажлаасаа цалинтай чөлөөлөгдөнө.

¹⁴ ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ тайландаа Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Говь-Алтай, Хэнтий, Хөвсгөл, Өмнөговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Завхан аймгууд болон нийслэл Улаанбаатар хотын төсөөллийг тусгасан. УХА-чид энэ мэдээллийг хэд хэдэн тохиолдолд сонгуулийн хороонуудын гишүүдийг томилох журам, гишүүдийн бүрэлдэхүүний үр дүнд хийсэн дүн шинжилгээгээр баталгаажуулах боломжтой байв.

¹⁵ Венецийн комиссын Сонгуулийн асуудлаарх сайн туршлагын дүрмийн 12-т байгаа II.2b-ийн 68-р заалтыг үзнэ үү.

¹⁶ Жишээлбэл СЕХ сонгуулийн үр дүнг парламентад илгээснээсээ хоёр хоногийн дараа эцсийн дүнг нийтэд мэдээлсэн.

ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-той хийсэн уулзалтуудын үеэр СЕХ-нд улс төрийн намуудын зүгээс ирдэг зохисгүй нөлөөний тухай хөндөж байсан ба МУЕСХ-ын цоорхойг, тухайлбал сонгуулийн хорооны гишүүнийг томилоход тавих шаардлага болон санал авах өдөр гарсан гомдолтой холбоотой зохицуулагдаагүй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх тухай нарийвчилсан журам гаргах эрх мэдэл байхгүй гэдгээ дурдаж байв.

Сонгуулийн байгууллагын хараат бус, бие даасан, ил тод байдлыг хуулиар хамгаалах болон уг байгууллагад итгэх илтгэлийг хадгалахтай холбоотой нэмэлт арга хэмжээг авах.

СЕХ 40 гаруй дүрэм журам, заавар, албан ёсны сонгуулийн баримт бичгийн загварыг баталсан төдийгүй СЕХ-ны шийдвэрүүдээрээ товхимол гаргасан ба тэдгээр товхимолыг доод шатны сонгуулийн хороод сонгуулийн санал авах өдрөөс өмнө болон санал авах өдөр ашигласан. Гэхдээ доод шатны сонгуулийн хороодод зориулсан иж бүрэн дүрэм журмыг СЕХ батлаагүй. СЕХ нь сонгуулийг удирдан явуулах үүрэгтэй байгууллага хэдий ч сонгуулийн хууль тогтоомжийн тогтвортой, жигд хэрэгжилтийг хангахад шаардлагатай алхмуудыг байнга авч хэрэгжүүлээгүй. Зарим асуудлууд, үүний дотор сонгогчдын нэрийн жагсаалтан дээрх сонгогчдын гарын үсгийн тоог олгосон болон санал өгсөн саналын хуудастай нэгтгэх, сонгуулийн урьдчилсан үр дүнг нийтлэх, эсвэл дүрс бичлэгийн камер суулгасан санал авах байруудаас дүрс бичлэг авч өргөдөл, гомдол хянан шийдвэрлэх явцад ажиглаж болох эсэх зэргийг зохицуулаагүй байна.¹⁷

Доод шатны сонгуулийн хороодын ажилд зориулсан иж бүрэн дүрэм журмыг СЕХ-гоор батлуулах шаардлагыг МУЕСХ-нд тусгах нь зүйтэй. Энэхүү дүрэм, журамд сонгуулийн өдөр ажиллах журам, ялангуяа сонгогчдын нэрийн жагсаалтанд дээр гарын үсэг зурсан сонгогчдын тоог олгосон болон санал авсан саналын хуудастай нэгтгэх, санал авах байрнуудын дотор дүрс бичлэгийн камер суурилуулах, дүрс бичлэгийг өргөдөл, гомдолыг хянан шийдвэрлэхэд ашиглах болон сонгуулийн үр дүнгийн хурлын тэмдэглэлийг олон нийтэд зориулан санал авах байрнуудад ил тавих.

СЕХ АНСХ-дийн дарга нарт цуврал сургалт явуулсан бөгөөд энэхүү хүмүүс нь холбогдох доод шатны хороодын гишүүдэд адилхан сургалт явуулсан байна. Энэхүү сургалт нь ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны УХА-даас эерэг үнэлгээ авсан билээ. Түүнчлэн СЕХ сонгогчдын боловсролын хөтөлбөр хэрэгжүүлсэн бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд сонгуульд санал өгөхийг уриалсан урилгыг сонгогч хэрхэн санал өгөх мөн зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөх талаар зааварчилсан хэвлэмэл хуудсын хамт хэвлүүлэн айл өрх бүрт тараасан ба санал өгөх талаар үндсэн мэдээлэл бүхий хоёр видео клипийг телевизүүдээр цацсан. Сонгогчдод зориулсан мэдээлэл болон саналын хуудсыг зөвхөн Монгол хэл дээр хэвлэсэн ба энэ нь олон улсын стандартаас зөрүүтэй юм.¹⁸ Бичиг үсэг тайлагдаагүй эсвэл Монгол хэлээр уншиж чадахгүй хүмүүст зориулан нэр дэвшигчдийн зургийг саналын хуудсанд оруулсан. СЕХ мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох эрхээ эдлэхэд туслах зорилгоор энэ ажлыг гүйцэтгэх ТББ-д санхүүжилт олгосон.

Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газраас сонгуульд идэвхтэй оролцож саналаа өгсөн сонгогч бүрт 1000 төгрөг (0.50 орчим евро)-ийн гар утасны нэгжээр урамшуулал олгох санаачлагыг СЕХ 6-р сарын 13-ны өдөр

¹⁷ Санал авах байрнуудаас дүрс бичлэг авч ашиглахдаа “хувийн, гэр бүлийн амьдрал, оршин суугаа газар, захидал харилцаа, цахим харилцаа холбоог хамгаалах эрх”-ийг дахин баталгаажуулсан ЕАБХАБ-ын 1991 оны Москвагийн баримт бичгийн 24-р заалтыг авч үзэх нь зүйтэй.

¹⁸ НҮБ-ын Хүний эрхийн хорооны ИУТЭОУХ-ийн Ерөнхий тайлбар №25 (1996)-ын 25-р зүйлийн 12 дахь заалтаар “[...] хэлний бэрхшээл [...] гэх мэт хүмүүсийг сонгох эрхээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд саад болдог онцлог бэрхшээлүүдийг давж гарахын тулд эерэг арга хэмжээг авах”-ыг шаарддаг.

албан ёсоор дэмжив.¹⁹ Энэ үйлдэл нь МУЕСХ-ийн хэд хэдэн зүйлийг зөрчсөн байх талтай ч²⁰ энэ санаачлагатай холбоотой албан ёсны аливаа гомдол гарсан тухай мэдээллийг ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ аваагүй болно.

А САНАЛ АВАХ ШИНЭ ТЕХНОЛОГИЙГ АШИГЛАСАН БАЙДАЛ

Сонгуулийн санал авах байр бүрт сонгогчийг танин баталгаажуулах хурууны хээ уншуулах машин болон санал тоолох автомат төхөөрөмж (СТАТ) байрлуулсан ба хурууны хээ уншуулах машиныг Улсын бүртгэлийн ерөнхий газрын ажилтнууд ажиллуулж байв. СТАТ нь санал уншуулах мөн тоолох зориулалттай машин ба сонгуулийн үйл ажиллагаа өндөрлөсөн даруйд сонгуулийн үр дүнг (үүнд хэвлэсэн тайлан багтана) СЕХ руу шууд дамжуулдаг. МУЕСХ-д санал хураалт дууссаны дараа АНСХ харьяа бүх хэсгээс санамсаргүй сонголт /сугалах/-ын аргаар суманд нэг, дүүрэгт хоёр хэсгийг сонгож саналын хуудсыг гар аргаар дахин тоолж хяналтын тооллого хийлгүүлнэ гэж заасан хэдий ч гар аргаар дахин тоолох хэсгийг хэрхэн сонгох талаар тусгай зохицуулалт МУЕСХ-нд байхгүй байгаа төдийгүй автоматаар болон гар аргаар тоолсон үр дүн зөрсөн тохиолдолд ямар арга хэмжээ авахыг тусгаагүй байна. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ныхонтой уулзаж ярилцсан хүмүүс, үүний дотор улс төрийн намууд СТАТ-ийн найдвартай байдалд эргэлзэж буйгаа илэрхийлсэн.

Ил тод байдлыг хангах, санал хураах шинэ технологи нь найдвартай гэдгийг батлахын тулд гар аргаар санал дахин тоолох СХХ-г санамсаргүй түүврийн аргаар сонгон авах процедурын баталгаа мөн гар аргаар болон машинаар тоолсон дүн зөрсөн тохиолдолд авах арга хэмжээг хуулинд тусгах асуудлыг авч үзэх.

СТАТ-ийг сонгууль явагдахаас өмнө хоёр удаа туршсан. Эхний туршилтыг МИДАС (Монголын мэдээллийн хөгжлийн холбоо) ТББ-аар 6 дугаар сарын 12-ны өдөр СЕХ-ны байранд намуудын төлөөлөгчид, хэвлэл мэдээлэл, ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ныг байлцуулан хийлгэсэн бол удаахыг нь бүх СХХ-оос авсан мэдээг цахим хэлбэрээр СЕХ-нд дамжуулах туршилтыг орон даяар 6 дугаар сарын 21-ний өдөр хийсэн. Гэсэн хэдий ч туршилтын ажил цэгч муутай явагдсан ба урьдаар тодорхойлсон албан ёсны шалгуур дээр үндэслээгүй болно. Энэ туршилтаас гадна, программын алдаанаас болж СТАТ нь хүчингүй саналын хуудасны тоог зөв тоолохгүй байгаа алдааг сонгуулийн өмнөхөн илрүүлсэн. СТАТ-ийг хүчингүй саналын хуудсын тоог мэдээлэхийн оронд хүчингүй саналын хуудсан дээр нэр дэвшигчдийн нэгийг тэмдэглэсэн тоог мэдээллэхээр программчилсан байлаа. СТАТ-ийг үйлдвэрлэсэн АНУ-ын Доминион Вөүтинг системс компани уг програмын алдааг баталсан хэдий ч эх сурвалж кодыг өгөөгүй. Уг компанийн мэдэгдсэнээр энэ алдаа хэтэрхий оройтож илэрсэн болохоор СТАТ-ийг санал авах өдөр ашиглахаар хүргэхээс өмнө уг төхөөрөмжийг дахин програмчлах боломжгүй гээд энэ алдаа нь үр дүнд нөлөөхгүй гэжээ. Гэхдээ нэр дэвшигч сонгогдохын тулд бүх саналын олонхийг авах ёстой тул СТАТ нь хүчингүй саналын хуудасны тоог үнэн зөв тогтоож мэдээлэх нь их чухал юм.

¹⁹ Холбогдох зардлыг үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид хариуцана. <http://gec.gov.mn/details/793> холбоосноос үзнэ үү.

²⁰ МУЕСХ-ийн 5.4-т заасны дагуу “Сонгогч сонгуульд оролцох эсэхээ бие даан шийдвэрлэх, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд нь албадан нөлөөлж, саад учруулах [аливаа].оролдлогыг хориглоно”. Энэ хуулийн 5.5-т “Сонгогч хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж, саналаа нууцаар гаргах боломжоор хангагдсан байна” гэж заасан. Түүнчлэн энэ хуулийн 43.8-т “Сонгууль зохион байгуулах хугацаанд гадаад, дотоодын тусламжийн эд хөрөнгийг иргэдэд тараах, худалдан борлуулж сонгуульд зарцуулахыг хориглоно” гэж заасан.

СЕХ, СТАТ нийлүүлсэн компанийн хамтын ажиллагаатайгаар уг төхөөрөмж сонгуулийн дүн, түүний дотор хүчингүй саналын хуудсын тоог багтаасан мэдээ тайланг үнэн зөв гаргах асуудлыг хангах. Түүнчлэн сонгуулийн өдрөөс нэлээн өмнө СТАТ-ийн үйл ажиллагаанд хөндлөнгийн буюу эрх бүхий гуравдагч талын үнэлгээ хийлгэн албан ёсны гэрчилгээ олгох үйл явцыг тогтоох. Ингэснээр СТАТ-ийг санал авах байрнуудад хүргэхээс өмнө болзошгүй алдааг засах боломжтой юм.

VI. СОНГОГЧИЙН БҮРТГЭЛ

Монгол Улсын сонгогчийн бүртгэл нь идэвхгүй, давтамжтай байдаг бөгөөд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын сангийн мэдээлэлд үндэслэгддэг. Иргэний бүртгэлийг хөтлөн явуулдаг УБЕГ нь бас сонгууль бүрийн өмнө сонгогчийн цахим бүртгэлийг бэлтгэдэг. МУЕСХ-д заасны дагуу сонгогчдын цахим бүртгэлийг олон нийтэд зориулан УБЕГ-ын цахим хуудсанд 3 сарын 1-ний өдөр байрлуулсан бөгөөд ингэснээр сонгогч бүр сонгогчдын жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ болон санал авах байрны байршил, дугаарыг регистер болон иргэний үнэмлэхний дугаараа оруулж шалгах боломжоор хангагдсан.

Хороо нэг бүрийн сонгогчдын нэрийн жагсаалтыг цахим хуудаст бүртгэгдсэн сонгогчийн бүртгэл дээр үндэслэсэн. Сонгогчдын нэрийн урьдчилсан жагсаалтыг сонгогчдын цахим бүртгэлд үндэслэн гаргаж хуульд заасан хугацааны дагуу 6 дугаар сарын 6-ны өдөр СХХ-нуудад хүргүүлсэн. 6 дугаар сарын 6-16-ны хооронд сонгогчид сонгогчдын нэрийн жагсаалтанд байгаа өөрсдийн мэдээлэлтэйгээ танилцах албан ёсны хугацааны үед өөрсдийн бүртгэлээ шалгах, бүртгүүлэх хүсэлтээ гаргах, мэдээллээ засах эсвэл санал авах өөр СХХ руу шилжих тухай хүсэлтээ өөрийн байнга оршин суугаа газрынхаа хэсгийн хороонд гаргах боломжтой.²¹ УБЕГ-аас сонгогчдыг мэдээллээ шалгахыг уриалсан сонгогчдын боловсролд зориулсан мэдээллийг зурагт, радиогоор 6 дугаар сарын 6-16-ны хооронд цацсан. Үүнээс гадна, энэхүү мэдээллэлтэй адил сурталчилгааны хуудсыг сонингоор дамжуулан түгээсэн.

ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны УХА-дын мэдээлсэнээр тэднийг сонгогчид нэрийн жагсаалтанд байгаа өөрсдийн мэдээлэлтэйгээ танилцах албан ёсны хугацааны үед СХХ-доор ажиглалт хийхэд сонгогчдын нэрийн жагсаалтыг олон СХХ-дын байруудад нийтэд ил байхаар тавиагүй байжээ. Гэхдээ өөрийн бүртгэлийг шалгахыг хүссэн сонгогчдод СХХ жагсаалтыг үзүүлэх боломж нээлтэй байлаа. СХХ-ны гишүүд айл өрх нэг бүрээр орж нягтлах болон сонгогчийн урилгыг хүргэх ажилд оролцсоноос болж энэхүү хугацаанд сонгогчдын нэрийн жагсаалт огт байхгүй байсан тохиолдлуудыг САХ тайландаа тусгасан.²² Сонгуулийн санал авах өдөр хүртэл цөөн хоног үлдээд байхад үйл ажиллагаагаа эхлээгүй байсан СХХ-нууд ч мөн байлаа. Энэ байдлаас болж сонгогчид бүртгэлээ баталгаажуулах, засвар оруулах боломжоор хангагдах 10 өдрийн үйл ажиллагааны хугацааг багасгасан. 6 дугаар сарын 16-наар дуусгавар болгож байгааг ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ныхонтой уулзаж ярилцсан зарим хүмүүс уян хатан биш, сонгуулийн санал өгөх өдрийг дөхүүлэн сонгогчид нэрийн жагсаалтанд бүртгүүлэх эсвэл бүртгэлийн алдааг зөв болгох боломжийг хязгаарласан хэмээн үзэж байв.

Сонгогчид нэрийн жагсаалттай танилцан өөрсдийн бүртгэлээ баталгаажуулах эсвэл алдаатай байвал засуулахад хангалттай хугацаа олгох үүднээс сонгогчдын нэрийн

²¹ Нийт 40,715 сонгогч өөр СХХ-нд шилжих хүсэлтээ гаргасан.

²² ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны УХА-чид СХХ-нууд санал өгөх урилгыг сонгогчид цаг хугацаанд нь хүргэсэн гэж тайландаа тусгасан. Мөн СХХ-нууд хорооныхоо сонгогчдыг байрлуулах боломжгүй байсан зарим тохиолдлыг тайландаа тусгасан.

жагсаалтыг санал авах байрнуудад 10 хоногийн турш албан ёсоор ил байлгаж байгаа хугацааны асуудлыг дахин нягталж үзэх.

Эмнэлэгт хэвтэж байгаа болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх эрхтэй бусад хүмүүс, тухайлбал биеийн эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр хүрэлцэн ирж чадахгүй, цэргийн алба хааж байгаа, хилийн харуулын үүрэг гүйцэтгэгч, урьдчилан хорих төвд хоригдож байгаа хүмүүсийн нэрийн жагсаалтыг тусад нь гаргасан. СЕХ-ны мэдээлсэнээр нийт 24,045 сонгогчид зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгөхөөр бүртгүүлсэн ба тэднээс 22,069 нь зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа 6 дугаар сарын 25-ны өдөр өгсөн.

МУЕСХ-иар гадаад улсад оршин суугаа иргэдийн санал өгөх бололцоог хангасан. Саналаа гадаадад өгөх хүсэлтээ гаргасан нийт 6,494 сонгогчийн 6,233 нь хуульд заасан хугацаанд буюу 5 дугаар сарын 29-ны дотор бүртгүүлсэн.²³ Нийт 4,242 сонгогч гадаадын дипломат төлөөлөгчийн газруудад байгуулсан 39 санал өгөх байруудад 6 дугаар сарын 14-16-ны өдрүүдэл саналаа өгчээ.

СЕХ-ны мэдээлсэнээр санал авах өдрөөс өмнө 1,856,190 сонгогчид сонгогчдын нэрийн жагсаалтанд бүртгэгдсэн²⁴ ба харин СЕХ-ны сонгуулийн албан ёсны батлагдсан үр дүнгээр нийт бүртгэгдсэн сонгогчдын тоо 1,864,273 байсан ба 8,083 сонгогчоор өсөлттэй байв. Нэмэгдсэн шалтгаан нь гадаадад байгаа сонгогчид болон сонгогчдын нэрийн жагсаалтыг нийтэд ил тавих албан ёсны хугацаанд хүсэлт гарган бүртгүүлсэн сонгогчдын бүртгэлтэй холбоотой гэж УБЕГ мэдээлсэн.

Уулзаж ярилцсан улс төрийн намуудын төлөөлөл сонгогчийн бүртгэлийн систем болон сонгогчийн нэрсийн жагсаалтын чанарт ерөнхийдөө итгэлтэй байгаагаа илэрхийлж байхад ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-тай ярилцсан бусад хүмүүс орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал болон УБЕГ-ын хоорондын уялдаа муу, хаягжилтын нэгдсэн систем байхгүйгээс зарим нэг шинээр баригдсан байрнуудад хаяг давхардан олгогдсон түүнчлэн зарим хаяг дээр сонгогчид олноороо бүртгүүлсэн тохиолдлуудыг мэдээлсэн. Тэдний үзэж байгаагаар энэ байдлаас болж сонгогчдын дунд эргэлзээ үүсэх, нэмэлт саад бэрхшээл үүсгэсэн. Жишээбэл: сонгогчдыг буруу санал авах байранд хуваарилсан байв.

Хаягжилтын системийг боловсронгуй болгох, сонгогчийн нэрийн жагсаалтыг үнэн зөв гаргах ажлыг сайжруулах үүднээс эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах.

VII. НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ

Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь сонгууль өгөх эрх бүхий, дөчин таван нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, эцэг эх хоёул Монгол Улсын харъяат

²³ МУЕСХ-д зааснаар 60 хоног эсвэл түүнээс илүү хоногоор гадаадад байх сонгогчийг сонгогчдын нэрийн жагсаалтаас түр хасах ба Монголдоо буцаж ирсэн сонгогчдийн хувьд 6 сарын 16-наас хэтрэхгүйгээр дахин бүртгэл хийлгэх шаардлагатай. СЕХ-ны мэдээлсэнээр түр хугацаагаар гадаадад байгаа иргэд гадаад оронд байгаа санал авах байранд бүртгүүлж, саналаа өгөх боломжтой. УБЕГ-ын мэдээллээр гадаадад саналаа өгөх хүсэлтээ гаргасан 261 сонгогчийн хүсэлтийг цахим үнэмлэхгүй, хуулиар шаардсан баримт бичгийн бүрдэл дутуу, эсвэл иргэний бүртгэлт байгаа нэр болон иргэний үнэмлэхийн дугаар тохирохгүй байна гэсэн үндэслэлээр татгалзжээ.

²⁴ УБЕГ-ын цахим хуудас <http://www.burtgel.mn> болон СЕХ-ны цахим хуудсыг үзнэ үү <http://gec.gov.mn/details/800>.

болохыг баталж чадах Монгол улсын уугуул иргэн байх ёстой. Эдгээр шаардлагууд нь хэт хязгаарласан шинжтэй байгаа бөгөөд ЕАБХАБ-ын үүрэг амлалт болон олон улсын бусад стандартуудтай нийцэхгүй байна.²⁵ Түүнчлэн, Үндсэн хууль болон МУЕСХ-ийн дагуу зөвхөн УИХ-д суудал бүхий улс төрийн нам, эвслээс ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй.²⁶ 1990 оны ЕАБХАБ-ын Копенгагены баримт бичгийн 7.5-р зүйл заалтаас ялгаатай нь ерөнхийлөгчийн сонгуульд хувь хүн бие даан нэр дэвших боломжгүй байна.

1990 оны ЕАБХАБ-ын Копенгагены баримт бичгийн 7.5 дахь хэсэг, мөн ардчилсан сонгуулийн төлөөх олон улсын стандартын нэр дэвшигчийг гарал угсаагаар ялгахгүй байх тухай шаардлагын дагуу холбогдох хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах, түүнчлэн эх орондоо байнга оршин суух тухай шаардлагыг дахин харгалзаж үзэх нь зүйтэй.

Энэ удаагийн сонгуульд гурван нэр дэвшигч өрсөлдөж АН-аас одоогийн Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж, МАН-аас УИХ-ын гишүүн Б. Бат-Эрдэнэ, мөн Монгол Улсын түүхэн дэх анхны эмэгтэй нэр дэвшигч болох МАХН-аас Эрүүл Мэндийн сайд Н. Удвал тус тус нэр дэвшив. Гурван нэр дэвшигч МУЕСХ-д заасан хугацаанд СЕХ-д бүртгүүлсэн.

VIII. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА

Сонгуулийн сурталчилгааны орчин өрсөлдөөнтэй, эвлэлдэн нэгдэх, цуглаан, хөдөлгөөн хийх үндсэн эрх, эрх чөлөөнд хүндэтгэлтэй хандсан байдалтай байсан ба өрсөлдөгчид сонгуулийн сурталчилгаагаа саад тотгоргүй явуулж, тэдний зохион байгуулсан цуглааны үеэр ямар нэг осол зөрчил гараагүй болно. МУЕСХ-д заасны дагуу нэр дэвшигчид СЕХ-ноос нэр дэвшигчээр бүртгэн үнэмлэх олгосон даруйд сонгуулийн сурталчилгаагаа эхэлсэн. Сонгуулийн сурталчилгаа явуулах хугацаа 6 дугаар сарын 24-ны 00 цагаас зогссон ба энэ хугацаанаас хойш сурталчилгаа явуулахыг хориглосон хуулийн заалтыг нэр дэвшигчид сахин биелүүлсэн болно. МУЕСХ-иар санал авах өдөр болон дахин болон нэмэлт санал хураалтын хооронд сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглосон. Гэхдээ хоёр дахь санал хураалт явуулах болсон тохиолдолд хэрхэхийг хуулинд тодорхой заагаагүй ч ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-нд СЕХ-ны мэдээлсэнээр энэ тохиолдолыг бас хориглох болно.

Сонгуулийн анхны санал хураалт болон хоёр дахь санал хураалтын хооронд, мөн дахин болон нэмэлт санал хураалт явуулах болсон тохиолдолд сонгуулийн сурталчилгаа явуулахыг МУЕСХ-иар зөвшөөрөх тухай нэмэлт өөрчлөлт оруулах.

²⁵ Нэр дэвшигчийн эцэг эх хоёул Монгол Улсын иргэн байна гэсэн шаардлага нь ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагены баримт бичгийн 7.3 дахь хэсэгт заасан сонгуулийн эрхийн нийтлэг шалгуурт нийцээгүй ба хязгаарлалт ихтэй байна. Уг баримт бичиг нь ЕАБХАБ-ын гишүүн орнууд “насанд хүрсэн иргэн бүрт нийтлэг, тэгш сонгуулийн эрх” баталгаажуулахыг даалгасан байдаг. Ерөнхий Тайлбарын 25-ын 15 дугаар хэсэгт сонгуульд оролцох эрхийг оршин суух газар, гарал үүслээр шалтгаалан хязгаарлах нь үндэслэлгүй, ялгаварлан гадуурхсан заалт болохыг тодорхойлжээ. Энэхүү заалт нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын конвенцид заасан үндэс яс, нийгмийн гарал, гарал үүсэл болон бусад байдлыг ялгаварлан гадуурхахыг хориглосон 2-р зүйлтэй бас зөрчилдөж байна.

²⁶ Сонгуулийн үйл явцад орох боломж, нэр дэвшүүлэх эрхийн хязгаарлалт нь сонгогчдын сонголтонд хязгаарлалт болж байна хэмээн үзэж, үүнд сэтгэл ханамжгүй байгаа тухайгаа зарим нэг жижиг улс төрийн намууд ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-д дуулгасан.

Сонгуулийн сурталчилгааны эхний шатанд сурталчилгааны ажил аядуу намуухан явагдаж, одоогийн Ерөнхийлөгчийг сурталчилгаага эрт эхлүүлсэн тухай гомдол,²⁷ СТАТ-ийг хэрэглэхтэй холбоотой асуудлууд голлож байсан бол сонгуулийн сурталчилгааны төгсгөл шатанд сурталчилгааны үйл ажиллагаа илүү харагдахуйц болж, өрсөлдөөн үндсэндээ одоогийн Ерөнхийлөгч болон Б. Бат-Эрдэнэ нарын хооронд өрнөсөн. Заримдаа үндсэрхэг өнгө аястай мэдэгдэл, улс төрийн туйлшрал ажиглагдаж байлаа.²⁸ Нэр дэвшигчдийн амлалтууд хоорондоо нэлээн давхцаж байсан хэдий ч нэр дэвшигч бүрийн мөрийн хөтөлбөрт бие биенээсээ ялгарах тодорхой сэдвүүд туссан байлаа.

Нэр дэвшигчид эсвэл тэдний төлөөлөгчдийн хооронд идэвхтэй мэтгэлзээн бараг өрнөсөнгүй. Нэр дэвшигчдийн дунд халз мэтгэлцээнийг ганцхан удаа Үндэсний олон нийтийн радио телевизээр 6 сарын 24-ны өдөр зохион байгуулсан ба халз мэтгэлцээний хэлбэр, зохион байгуулалтыг нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааны багуудаар урьдчилан гаргуулсан нь тодорхой сэдвүүдийг хөндөх²⁹ болон цаг хугацааны хувьд хязгаарлагдсан, хэлэлцүүлэг өрнөх боломж багатай болсон.

Өнөөгийн Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж болон АН-ын төлөөлөгчидийн зүгээс СТАТ-ийг ашиглах ач холбогдлыг “шударга ёсыг дээдлэх ашиг сонирхолд нийцнэ”³⁰ гэж удаа дараа онцолж байсан бол, МАН-аас нэр дэвшигч Б. Бат-Эрдэнэ болон МАХН-аас нэр дэвшигч Н.Удвал нар СЕХ-ноос СТАТ-ний талаар сонгогчдод зориулан гаргасан мэдээлэл хангалтгүй гэж үзэхийн зэрэгцээ автоматаар болон гар аргаар тоолсон дүн нийцэхгүй тохиолдолд СЕХ-ноос үүнийг зохицуулах зохицуулалтгүй байна хэмээн онцолж байлаа.³¹ 6 дугаар сарын 5-ны өдөр нэр дэвшигч Б. Бат-Эрдэнэ автоматаар санал тоолох үйл явц нь ил тод биш, сонгогчид үүнд үл итгэдэг гэх үндэслэлээр хүн ам ихээр төвлөрсөн аймаг, хотуудад³² саналын хуудсыг гарааг тоолох саналд нэгдэхийг нөгөө хоёр нэр дэвшигчиддээ хандан уриалсан. Үүний

²⁷ ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ныхны уулзаж ярилцсан зарим хүмүүс одоогийн Ерөнхийлөгчийг сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлэхээс өмнө сурталчилгааныхаа ажлыг эхлүүлсэн хэмээн гомдоллож байсан. 5 дугаар сарын 17-20-ны хооронд урт хэмжээний ярилцлагыг үзэгчдийн оргил цагаар янз бүрийн зурагтын сувгаар өгсөн хэмээжээ. Үүнээс болж МАН сонгуулийн сурталчилгаага хугацаанаас өмнө эхлүүлсэн хэмээн үзэж Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ) болон цагдаад гомдол гаргасан бөгөөд тэрхүү гомдлыг ШӨХТГ одоогийн Ерөнхийлөгчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс нэвтрүүлгийн ярилцлагад яригдаагүй байна гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон. САХ-ны томилолт дуусах хүртэл буюу 7-р сарын 11-ний байдлаар цагдаагийн байцаан шалгах ажиллагааны үр дүн хэрхсэн талаар мэдээллийг САХ аваагүй болно.

²⁸ 6 дугаар сарын 11-нд Дорнод аймагт болсон Б. Бат-Эрдэнийн сонгуулийн сурталчилгааны цуглааны үеэр түүний төлөөлөгчид өөрийн нэр дэвшигчээ Хэнтий аймагт төрсөн болохоор бусад нэр дэвшигчдээс давуу гээд “жинхэнэ” Монгол хүмүүс Завхан, Говь-Алтай, Ховд аймгуудад бус төвийн аймгуудад амьдардаг хэмээн онцолжээ. Энэ талаар 6 дугаар сарын 12-ны Өдрийн сонин дээр нийтэлжээ. Баруун аймгийнхан, ялангуяа Увсчууд энэхүү мэдээллийн эсрэг эсэргүүцлээ илэрхийлжээ. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны УХА-чидын ажиглалтаар Н. Удвал харийнханд эх орноо худалдах асуудлыг эцэс болгох мөн гадаадын хөрөнгө оруулалтыг бууруулна хэмээн 5 дугаар сарын 23, 6 дугаар сарын 3-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Өндөрхаан, 6 сарын 2-ны Дорнод аймгийн Чойбалсан, 6 сарын 13-нд Говьсүмбэрийн Чойр болон 6 сарын 18-нд Баян-Өлгий аймгийн Өлгий сумдуудад хийсэн сурталчилгааны үеэр амлажээ.

²⁹ Эдгээр сэдвүүдэд нэр дэвшигчдийн ирээдүйн тэргүүлэн авч үзэх ерөнхий асуудлууд, эдийн засгийн хөгжил, шүүхийн бие даасан, хараат бус байдал, батлан хамгаалах бодлого, уул уурхай, үндэсний өв соёл, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, газар тариалан, үндэсний аюулгүй байдал, төвлөрөлийг сааруулах болон авлигын асуудлууд багтана.

³⁰ 4-р сард Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Сайд нарын 7-р бага хурлын тухай үзнэ үү <http://cdmongolia.mn/sttaments/>.

³¹ Цахим байдлаар санал тоолох аргыг нэвтрүүлэхийг дэмжсэн парламентад суудалтай улс төрийн намуудын нэг нь МАН байсан. Тус нам 2012 оны парламентийн болон орон нутгийн сонгуулийн автомат болон гар аргаар тоолсон саналын үр дүн нийцэхгүй байсан тухай бас тэмдэглэн хэлсэн.

³² Улаанбаатар хот, Дархан –Уул, Орхон, Хөвсгөл аймгууд.

хариуд СЕХ нь 6 дугаар сарын 6-ны өдөр МАН-д албан бичгээр МАН-ын нэр дэвшигч МҮЕСХ-ийг зөрчихийг уриалахгүй байхыг шаардав. Түүнчлэн ШӨХТГ³³ нь АН-аас ирүүлсэн гомдлын дагуу шалгалт хийн нэр дэвшигч Б. Бат-Эрдэнийн уриалгыг МҮЕСХ-ийн 33.7.7 дахь заалтыг зөрчсөн гэж үзэн түүнд анхааруулга өгсөн.³⁴ МАН гар аргаар тоолохын төлөөх ухуулгаа үргэлжлүүлсээр байв. Өнөөдөр сонины 6 дугаар сарын 19-ны дугаарт ЦЕГ-аас МАН энэхүү үйлдэл нь олон нийтэд нөлөөлөн нийгмийн хэв журам алдагдуулж болзошгүй хэмээн анхааруулсан.

Сонгуулийн сурталчилгааны тэгш боломжийг хангах зорилготой хязгаарлалтуудыг шинэ МҮЕСХ-иар тогтоосон. Тухайлбал бэлэн мөнгө тараах, Ерөнхийлөгчийн гүйцэтгэх бүрэн эрхэд хамааралгүй аливаа төрлийн амлалт өгөхийг хориглосон.³⁵ ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны УХА-дын ажигласнаар гурван нэр дэвшигч гурвуулаа МҮЕСХ-ийг зөрчин санхүүгийн чанартай амлалтууд өгсөн тохиолдол гарсан.³⁶ Иймэрхүү хэд хэдэн тохиолдолд МАН болон АН-ын аль аль нь гомдол гаргасан.³⁷ МҮЕСХ-иар бусдыг гүтгэх, доромжлох, нэр төрийг нь гутаах, түүнчлэн улс төрийн оролцогч талаас худал мэдээлэл тараахыг илт хориглосон ба энэ нь сонгуулийн нөхцөлд үзэл санаагаа чөлөөтэй илэрхийлэх гэсэн олон улсын стандартын хүрээнээс өөр байна.³⁸ Сонгуулиас өмнө тодорхой хугацаанд

³³ Бие даасан, байнгын үйл ажиллагаатай хэвлэл мэдээллийн зөвлөл байхгүйгээс СЕХ/Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-ноос 4-р сарын 5-ны өдөр гаргасан тогтоолын дагуу “Радио, телевизээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх” журмыг ШӨХТГ хянана. Хяналт тавих техник хэрэгсэл, арга зүй дутмаг байдлаасаа болж ШӨХТГ тоон болон чанарын хяналт хийж чадахгүй зөвхөн өргөдөл гомдол ирсэн тохиолдолд хариу арга хэмжээ авдаг. Холбогдох хуулийн заалтуудыг зөрчсөн тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусгай зөвшөөрлийг гурав хүртэлх сарын хугацаагаар ХХЗХ-ноос түтгэлзүүлэх боломжтой.

³⁴ МҮЕСХ-ийн 33.7.7 заалтаар “сонгуульд оролцохоос татгалзах, сонгуулийн болон бусад хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулах”-ыг хориглосон.

³⁵ Нэр дэвшигчид ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрэн дэх чиглэлүүдээс зөвхөн шүүх эрх мэдлийн шинэтгэл, гадаад харилцаа гэсэн хоёр чиглэлийг онцолсон. Бусад нь ерөнхийдөө бэлэгдлийн чанартай болно. Бүх нэр дэвшигчид мөрийн хөтөлбөртөө авлига, ажилгүйдэл, уул уурхайгаас үүдэлтэйгээр нийгэм, байгаль орчин, эдийн засаг, засаглалд үзүүлж буй сөрөг нөлөө, болон архидалтай тэмцэх, түүнчлэн шүүх эрх мэдлийг шинэчлэх, нийтийн албыг улс төрөөс ангид байлгах, амжиргааны түвшинг сайжруулах, сургууль, эмнэлэгт оруулах хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, ОХУ болон БНХАУ-тай сайн харилцааг эрхэмлэх гадаад бодлогыг үргэлжлүүлнэ гэж амласан.

³⁶ Ийм амлалтуудыг Ц. Элбэгдорж 5 дугаар сарын 22-ны өдөр Чойбалсан (Дорнод аймаг), 6 дугаар сарын 4-ны өдөр Алтай (Говь-Алтай аймаг), 6 дугаар сарын 6-ны өдөр Өлгий (Баян-Өлгий аймаг), 6 дугаар сарын 9-ны өдөр Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг, 6 дугаар сарын 11-ны өдөр Зуунмод (Төв аймаг), 6 дугаар сарын 16-ны өдөр Сайхан сум (Сэлэнгэ аймаг)-д ажиллахдаа өгсөн. Дэлгэрэнгүйг ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны Урьдчилсан Тайлан Дугаар 01-ээс үзнэ үү. Б. Бат-Эрдэнэ дунд сургууль, цэцэрлэг барих түүнчлэн залуучуудыг хямд үнэтэй орон сууцаар хангах (Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, 6 дугаар сарын 8-ны өдөр), оюутнуудад сар бүр 70,000 төгрөгийн тэтгэлэг олгох хөтөлбөрийг үргэлжлүүлэх (6 дугаар сарын 10-ны өдөр Сэлэнгэ аймаг Сүхбаатар, 6 дугаар сарын 19-ны өдөр Өмнөговь аймаг Даланзадгад) тухай амлав. Үүнээс гадна тэрээр 6 дугаар сарын 10-ны Дархан-Уул аймагт ажиллах үеэрээ Монгол Улсын иргэн бүрт олгох Оюу Толгой компанийн 1,072 ширхэг хувьцаантай холбоотой амлалтуудыг өгсөн. Н. Удвал бас оюутнуудад тэтгэлэг олгох амлалт өгсөн ба уул уурхайн орлогоос гэхээс илүүтэйгээр татвар төлөгчдийн мөнгөөр тэдэнд тэтгэлэг олгоно гэв (6 дугаар сарын 18-ны өдөр Баян-Өлгий аймаг, Өлгий).

³⁷ МАН гомдлоо 5 дугаар сарын 25-ны өдөр Нийслэлийн цагдаагийн газарт гаргав. (ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны Урьдчилсан Тайлан Дугаар 02-оос үзнэ үү) АН нэр дэвшигч Б. Бат-Эрдэнийн хэд хэдэн ТВ-ийн сувгаар улс төрийн сурталчилгааны хэлбэрээр гаргасан оюутны тэтгэлэгийг үргэлжлүүлнэ гэсэн амлалттай холбоотой гомдлыг СЕХ-нд гаргав (хувийг ШӨХТГ хүргүүлэв).

³⁸ НҮБ-ын Хүний эрхийн хорооноос гаргасан ИУТЭОУХ-ийн 25 дугаарын Ерөнхий тайлбарын 25-р зүйлийн 25-р хэсэгт “иргэд, нэр дэвшигч болон сонгогдсон төлөөлөгчид олон нийт болон улс төрийн тухай асуудлаар мэдээлэл, саналаа хоорондоо чөлөөтэй харилцах нь чухал” гэж заасныг үзнэ үү.

олон нийтийн санал асуулга явуулах, энэ төрлийн мэдээллийг нийтлэхийг мөн хориглосон байна.³⁹

ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагены баримт бичгийн 7.7-р зүйл заалтын шаардлагын дагуу улс төрийн намуудад сонгуулийн сурталчилгаагаа чөлөөтэй явуулах боломж олгохын тулд сонгуулийн сурталчилгаа явуулах журмын хязгаарлалтуудыг багасгах нэмэлт өөрчлөлтийг МУЕСХ-нд оруулах.

ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны УХА-чид орон даяар нийт 56 сонгуулийн үйл явдлыг ажиглалаа.⁴⁰ УХА-дын ажигласнаар цуглаанд оролцогсдын 54 орчим хувь нь дунджаар эмэгтэйчүүд байлаа. Нэр дэвшигчдийн сурталчилгааны харагдах байдал аймгуудын хооронд төдийгүй аймаг дотроо их өөр байсан. 2012 оны Улсын Их Хурлын болон Орон нутгийн сонгуулийн үеэр холбогдох нэр дэвшигч намыг дэмжих үйл ажиллагаа бүс нутгийн түвшинд илүү явагдаж байсан ба нөгөөтэйгүүр нэр дэвшигчдийн санхүүгийн эх сурвалжид бас тусгалаа олж байлаа. Нэр дэвшигчид бүгдээрээ аймаг, нийслэл, дүүргийн түвшинд сурталчилгаагаа явуулж байсан бол тэдний төлөөлөгчид хөдөөгүүр болон жижиг суурингуудаар сурталчилгааг түлхүү явуулж байлаа. Зарим дүүргүүдийн хувьд нэр дэвшигчийн ирэхийн өмнөх өдөртөө бараг зэрэгцэн сонгуулийн сурталчилгаа хийгдэж байв. МАН болон АН-ын хувьд сонгуулийн сурталчилгааныхаа нугалбар, нам/нэр дэвшигчийнхээ тухай сонинг тараахдаа олон тооны албан байрыг ашигласан ба үүнд сурталчилгааны гэрүүд багтана. Түүнчлэн намын ухуулагчид айлаас айл дамжин ухуулга сурталчилгаа хийж байв. Сонгуулийн санал авах өдөр ойртох тусам гурван нэр дэвшигчийн зурагт хуудас, намынх нь туг СХХ-ны ойр хавьд түүнчлэн хувийн байшин болон гэрүүд дээр элбэг үзэгдэж байв.⁴¹

Бүх нэр дэвшигчдийн сурталчилгааны арга хэмжээнд Засгийн газрын сайдууд, Улсын Их Хурлын дэд дарга нар, УИХ-ын гишүүд, Иргэдийн хурлын төлөөлөгчид, Засаг дарга нар төдийгүй олны танил бөхчүүд, сумо бөхийн аваргууд, эмч, жүжигчин, яруу найрагчид оролцож байсныг ажигласан. Үүнээс гадна, одоогийн ерөнхийлөгчийг дэмжих уулзалтын үеэр Ерөнхий сайд, УИХ-ын дарга, Засгийн газрын агентлагуудын дарга нар, Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдын зөвлөхүүд, Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга нар ирэн дэмжиж байсныг ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ ажигласан. Нэр дэвшигчид болон тэдний төлөөлөгчид цахим мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ (social network), тухайлбал фэйсбүүк, твиттерийг идэвхтэй ашиглахаас гадна гар утас руу сонгуулийн сурталчилгааныхаа мессежийг илгээсэн.⁴²

³⁹ Хэдийгээр МУЕСХ-ийн 33.6-р заалтаар аливаа этгээд санал авах өдөр хүртэлх долоо хоногийн хугацаанд нам, нэр дэвшигчдийн талаар санал асуулга явуулах, энэ төрлийн мэдээллийг бүх төрлийн мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтлэх, тараахыг хориглож байгаа ч ШӨХТГ-ын зүгээс санал асуулгыг нийтлэхийг 2013 оны 1-р сарын 1-нээс санал авах өдрийг хүртэл хориглосон байна.

⁴⁰ ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны УХА-чид Ц. Элбэгдоржийг дэмжсэн 23, Н. Удвалыг дэмжсэн 15, Б. Бат-Эрдэнийг дэмжсэн 18 цуглааныг ажиглалаа. Цуглаан бүрт оролцогчдын тоо харилцан адилгүй байсан ба 60-6,500 хүний хооронд байв. Ажиглалт хийсэн цуглаанд оролцогчдын ойролцоогоор тавны нэг хувь нь залуучууд байлаа.

⁴¹ ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ хоёр хэл (Монгол-Казак) дээр бичигдсэн сурталчилгааны самбар, зурагт хуудас байхыг Баян-Өлгий аймагт ажиллахдаа анзаарсан.

⁴² Сонгуулийн сурталчилгааны сүүлчийн өдөр Б. Бат-Эрдэнэ залуучуудад хандан урьдчилгаа төлбөргүйгээр хямд үнэтэй орон сууцны зээлд хамруулах, түүнчлэн амжилттай суралцаж байгаа оюутнуудыг түр хугацаагаар дэмжих тухай мессежийг илгээсэн.

IX. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ САНХҮҮЖИЛТ

МУЕСХ-ийн дагуу зөвхөн улс төрийн нам болон нэр дэвшигчдийг санхүүжүүлэх эх сурвалжийг хандиваар бүрдүүлэхээр зохицуулжээ. СЕХ-ны 2013 оны 2 дугаар сарын 22-ны өдөр баталсан 4-р тогтоолоор нам тус бүрийн сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг 5.1 тэрбум төгрөг (сурталчилгааны хугацаанд ойролцоогоор 2.7 сая евро), нэр дэвшигч тус бүрийн сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг 3.1 тэрбум төгрөг (ойролцоогоор 1.6 сая евро) байхаар тогтоосон.⁴³ Сонгуулийн сурталчилгааны хандивыг зөвхөн сонгуулийн жилд өгөх ба хандивын хэмжээг дөчин ширхэг нэг сарын цалингийн хамгийн доод хэмжээнд байхаар буюу иргэн арван сая төгрөг (5,300 орчим евро), хуулийн этгээд тавин сая төгрөгөөс илүүгүй байхаар тогтоожээ. Тодорхой эх сурвалжаас хандив авахыг уг хуулиар хориглосон.⁴⁴ Энэхүү заалтыг зөрчвөл бага хэмжээний торгууль оногдуулах ба хэтэрч болох хандивтай харьцуулахад хэмжээний хувьд бага юм. Гэхдээ СЕХ-ноос тогтоосон хязгаараас давсан мөнгийг хураахаар зохицуулжээ. Намын сонгууль эрхэлсэн байгууллага санал хураалт дууссан өдрөөс хойш 30 хоногт багтаан нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг гаргасан ба сонгуулийн үед нэр дэвшигчид нийтэд санхүүгийн мэдээлэл хийгээгүй болно. МУЕСХ-иар хандивлагч иргэн, эсвэл хуулийн этгээдийн овог нэр, оршин суугаа газрын хаяг болон хандивын хэмжээг заасан тайланг гаргах, мөн СЕХ эдгээр тайланг хүлээн авах, хянах, санал хураалт дууссан өдрөөс хойш 45 хоногийн дотор дүнг нийтэд мэдээлэх зэрэг нарийвчилсан шаардлагуудыг зааж өгчээ.

СЕХ-ноос ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-нд мэдээлсэнээр энэ үйл явцад СЕХ зөвхөн зуучлагчийн үүрэгтэй ба тайланд аудит хийдэггүй гэсэн ч МУЕСХ-иар СЕХ-ноос шаардлагатай гэж үзвэл улс төрийн нам эсвэл нэр дэвшигчийн санхүүжилт болон зардлыг хянуулахаар төрийн аудитад хүсэлт гаргах эрх олгосон байна. СЕХ нь улс төрийн намын санхүүжилт, түүнчлэн сонгуулийн бүх хорооны нягтлан бодох бүртгэлийн зардлыг хянах ажлыг зөвхөн нэг хүнд даалгасан байсан бөгөөд энэ мэт хүчин зүйлээс болж МУЕСХ-нд оруулсан хяналтын хөшүүргүүдийн үр дүнг сулруулах, сонгуулийн сурталгааны санхүүжилт хийгдэж байгаа байдалд итгэх иргэдийн итгэл буурах талтай хэмээн ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-той уулзаж ярилцсан иргэний нийгмийн төлөөлөл онцолж байсан юм.

СЕХ нь сонгуулийн сурталчилгааны санхүүжилтын ил тод байдал болон санхүүжилтын шуударга байдалд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхийн тулд сонгуулийн сурталчилгааг санхүүжүүлэх тухай журмыг хугацаанд нь нийтлэх, сурталчилгааны санхүүжилтыг, үүний дотор сонгуулийн өмнөх үеийн санхүүжилтыг хянаж чадах ил тод, хэрэглэхэд үр дүн сайтай журмыг хэрэглэх.

X. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

A Эрх Зүйн Орчин

Монгол Улсын Үндсэн хуулиар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг баталгаажуулсан. Хэвлэл мэдээллийн салбарт эрх зүйн орчинд шинэчлэлт хийгдэх хүрээнд төрөөс хэвлэл мэдээлэлд цензур тогтоохыг хориглосон 1998 онд батлагдсан Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, мөн төрийн өмчид байсан Монголын

⁴³ Зардлын дээд хэмжээг зөвхөн СЕХ-ны зах зээлийн судалгаан дээр үндэслэсэн тогтоосон ба СЕХ-ны 4-р тогтоолтой олон нийт танилцах боломжгүй байсан.

⁴⁴ Гадаад улс, гадаадын байгууллага, эсвэл гадаад улсын иргэн, төрийн эсвэл орон нутгийн эрх бүхий байгууллагууд, эсвэл эдгээрийн эзэмшлийн хуулийн этгээд, өр төлбөртэй хүмүүс, үйлдвэрчний эвлэл, шашны болон төрийн бус байгууллагууд үүнд орно.

Үндэсний телевизийг 2005 онд Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар олон нийтэд үйлчлэх статуст шилжүүлсэн орно. Иргэний нийгмийн байгууллагуудын 8 жилийн нөлөөллийн кампанит ажлын дүнд Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийг 2011 онд баталсан нь ихээхэн ач холбогдолтой юм. Үндсэн хуулиар мэдээлэл хайх (“төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй”) хүлээн авахыг баталгаажуулан,⁴⁵ түүнчлэн Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль энэхүү эрхийг хамгаалж байгаа ч Төрийн нууцын тухай хууль болон бусад хуулийн заалтаар буруугаар хязгаарласан байдаг.⁴⁶

Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин дахь нэг гол дутагдал бол гүтгэх, доромжлох хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэсээр байгаа явдал.⁴⁷ Иймэрхүү хэрэгт төрийн албан хаагчаас сэтгүүлчийн эсрэг гаргасан гомдолд хорих ял шийтгүүлэх боломжтой төдийгүй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг жар дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох явдал нь, өөрийгөө цензурдэх байдлыг нь хэт өгсөнө.

Олон улсын холбогдох стандартын дагуу гүтгэх доромжлох хэргийг эрүүгийн хуулиар шийтгэх явдлыг цуцалж иргэний хуулиар шийдэх асуудлыг авч үзэх хэрэгтэй. Цаашилаад, гүтгэх, доромжлох хэрэгт иргэний хуулиар оногдуулах шийтгэл нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд сөргөөр нөлөөлөх хэмжээний их биш, харин нэхэмжлэгчид нөхөн олговор олгож, хариуцагчийг шийтгэх бус сэвтсэн нэр хүндийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг авах нь зүйтэй. Ялангуяа, учирсан бодит хохиролтой яг дүйцэх мөнгөн торгууль ногдуулах ба хуулиар мөнгөн бус зохицуулалтыг тэргүүн ээлжинд ашиглах нь зүйтэй.

Сайтууд дахь сэтгэгдлийн харилцааг зохицуулах журмыг Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-ны 2013 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн тогтоолоор баталсан ба “гүжирдлэг, доромжлол, хараал зүхэл болон айлган сүрдүүлэлт”-ийн эсрэг тэмцэх зорилготой. Энэ журмаар хэрэглэгчийн үүсгэх контент, түүнтэй холбоотой асуудлуудыг зохицуулах үүргийг сайтуудад оногдуулсан. Энэхүү үүрэгт “Та сэтгэгдэл бичихдээ хууль зүйн болон ёс суртахууны хэм хэмжээг хүндэтгэнэ үү. Хэм хэмжээг зөрчсөн сэтгэгдлийг админ устгах эрхтэй” гэсэн анхааруулгыг сэтгэгдлийн талбарт харагдахуйц байршуулах үүрэг багтана. Засгийн газар эсвэл арилжааны үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагаас оногдуулсан болон эцсийн хэрэглэгчийн хяналтанд бус агуулгыг филтердэх систем нь урьдчилан цензурдэх хэлбэр ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд тавих хязгаар биш юм.⁴⁸

⁴⁵ Үндсэн хуулийн 16.17-р зүйл.

⁴⁶ Мэдээллийн эрх чөлөө үүний дотор нийтийн албаны эрх мэдэлтэнд байгаа мэдээллийг авах эрх нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх баталгааны үндсэн бүрдэл юм. Энэхүү зарчим нь зөвхөн онцгой хязгаарлалт урьдчилсан байдлаар үндэсний аюулгүй байдалд бодитоор болон гарцаагүй заналхийлж байгаа тохиолдолд хуулинд тусгагдсан байх ёстой. Мэдээллийн эрх чөлөөнөөс давсан нууцлалын бусад заалтуудыг хүлээн зөвшөөрөх нь эдгээр зарчмуудыг хүндэтгэхгүй байгаа хэрэг болно. ИУТЭОУХ-ийн 19-р зүйл <http://www.ohchr.org/en/professionalinterest/pages/ccpr.aspx>, НҮБ-ын Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний тухай Тусгай илтгэгчийн тайлбар [http://www.unhcr.ch/Huridocda/Huridoca.nsf/0/16583a84ba1b3ae5802568bd004e80f7/\\$FILE/G0010259.pdf](http://www.unhcr.ch/Huridocda/Huridoca.nsf/0/16583a84ba1b3ae5802568bd004e80f7/$FILE/G0010259.pdf), түүнчлэн НҮБ, ЕАБХАБ, Америкийн Улсуудын байгууллага (ОАС)-ын гурван тусгай илтгэгчийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх талаар 2004 оны 12-р сарын 6-нд хамтран гаргасан тунхаглал <http://www.osce.org/fom/38632>-ыг тус тус үзнэ үү.

⁴⁷ Гүтгэх гэмт хэргийг эрүүгийн хуулиас халах тухай өөрчлөлт оруулах Эрүүгийн хуулийн төслийг 2013 онд УИХ-аар хэлэлцэх байх. ИУТЭОУХ-ийн тухай Монгол Улсын 2011 оны илтгэлийг дагалдан гарсан НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны зөвлөмжийг http://ccprcentre.org/doc/HRC/Mongolia/CCPR.C.MNG.CO.5_en.pdf-ээс үзнэ үү.

⁴⁸ ЕАБХАБ-ын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний төлөөлөгч НҮБ, Америкийн Улсуудын байгууллага, Хүний ба улс түмний эрхийн төлөөх Африкийн комисс-ын тусгай илтгэгчидтэй хамтран гаргасан Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба Интернэт хамтарсан тунхаглалыг <http://www.osce.org/fom/78309> -өөс үзнэ үү.

Цахим хуудсаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэтэрхий хязгаарлаж байгаа арга хэмжээнүүдийг зогсоох талаар анхаарч үзэх, цаашилаад хэрэглэгчийн бичсэн зүйлийн агуулгад мониторинг хийхийг интернэтийн зуучлагчид үүний дотор үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага болон бусад хүмүүсийн тависан материалыг эзэмшигчдээс шаардахгүй байвал зохилтой. Мөн тэднийг агуулгыг авч хаях үндэслэлгүй буюу хуулиас гадуур дүрмийн субъект үл болгохыг зөвлөж байна.

В ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ОРЧИН

Хэвлэл мэдээллийн зах зээл улс төрийн олон ургалч үзлийг тодорхой түвшинд зөвшөөрдөг ба энэ байдлаас болж маш олон тооны хэвлэл мэдээллийн хэрэгслүүд улс төрийн оролцогчдын шууд болон шууд бус эзэмшилд байдаг. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-нд сэтгүүлчдийн мэдээлсэнээр мэдээний хөтөлбөрүүдэд нэвтрэх хоёр түгээмэл туршлага байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эздээр дамжуулах, эсвэл төлбөр төлөх. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэд улс төрийн өрсөлдөгчдөө гүтгэн доромжилсон “Хар ПР” гаргах зорилгоор нөлөөлдөг тухай тэд хэлсэн.⁴⁹ Эзэмшигчийн ил тод бус байдал нь олон нийт хэвлэл мэдээллээр цацагдаж байгаа мэдээллийг бүрэн дүүрэн үнэлэж цэгнэх боломж хязгаарлагдаж байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшллийн ил тод байдал, редакцын хараат бус байдлыг зохицуулах заалтыг тусгасан Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг Ерөнхийлөгч УИХ-д өргөн барисан боловч хоёр дахь уншилтын дараа Ерөнхийлөгч 2013 онд буцаан татсан болно.⁵⁰ Редакцийн бие даасан байдал дутмаг байгаагаас эрэн сурвалжлах сэтгүүл зүй болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн ардчилсан чиг үүрэг ерөнхийдөө алдагдаж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эздийн нэрийг ил болгох зохицуулалтыг хэвлэл мэдээллийн эрх зүйн орчинд бий болгох хэрэгтэй. Цаашилаад хэвлэл мэдээллийн хэрэгслийн эздийг редакцын хараат бус байдлыг баталгаажуулах байдлын заалтуудыг эзэд редакцын албаныхантай гэрээ байгуулах хэрэгтэй. Үүрэг оноосон заалтыг хэвлэл мэдээллийн тухай хууль тогтоомжинд тусгах.

МУЕСХ-д заасны дагуу МҮОНТ нь нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааг СЕХ-ны бэлтгэж өгсөн хуваарийн дагуу үнэ төлбөргүй нэвтрүүлэх үүрэгтэй, харин арилжааны телевизүүд ижил хэмжээтэй төлбөртэй цагийг нэг өдөрт нийт нэг цаг байхаар нэр дэвшигчдэд гаргаж өгдөг. Энэ зохицуулалт дээр нэмэгдэн СЕХ болон ХХЗХ-ны 4-р сарын 5-ны өдрийн хамтарсан тогтоолоор “Радио, телевизээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх журам” гаргасан хэдий ч сонгуулийн сурталчилгааг мэдээний хөтөлбөрөөр гаргаж болох эсэхийг МУЕСХ-иар тодорхой зохицуулаагүй байна.⁵¹ Мөн сонгуулийн сурталчилгааны үед редакцтай холбоотой асуудлыг хэрхэн зохицуулах тухай хөндөөгүй байна.⁵² ШӨХТГ-аас ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-нд

⁴⁹ Ийм туршлага нэлээд нийтлэг байдаг бөгөөд өмнөх сонгуулийн сурталчилгааны үеэр зарим нэг телевизүүд зөвхөн сонгуулийн хугацааны үеэр үйл ажиллагаа явуулсанаас болж ийм байдал нэмэгдсэн.

⁵⁰ Уулзалж ярилцсан ганц нэг хүний тайлбарласнаар бол хэвлэл мэдээллийн хэрэгслийн эздийн зүгээс ирсэн дарамтаас болж хуулийн төслийг татсан гэв.

⁵¹ Сонгуулийн сурталчилгааг мэдээний хөтөлбөрөөр явуулж болох эсэхийг тодруулахаар МҮОНТ-ийн бичгээр илгээсэн хүсэлтэнд СЕХ албан ёсоор хариулаагүй. Мэдээний хөтөлбөрөөр сонгуулийн сурталчилгаа явуулах нь хуулийн заалт зөрчсөн үйлдэл биш гэсэн аман хариултыг авсан тухайгаа МҮОНТ ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-нд мэдээлсэн.

⁵² Европын зөвлөлийн Сонгуулийн сурталчилгааны үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргах агуулгын тухай зөвлөмжинд “хэвлэл мэдээллийн хэрэгслийн редакцийн бие даасан байдлыг хангах үндсэн зарчим сонгуулийн үед онцгой ач холбогдолтой” гэж онцолжээ. Үүнийг <https://wcd.coe.int/ViewDoc.jsp?id=419411> үзнэ үү.

мэдээлсэнээр, хуулийн заалтыг дагаж мөрдөхийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүх нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааг мэдээний хөтөлбөрөөр ижил хэмжээтэй гаргах, мөн улс төрийн намын сурталчилгааг ижил хэмжээгээр цацах хэрэгтэй гэлээ.

Олон нийтийн болон хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээний хөтөлбөр, хэлэлцүүлэг, мэтгэлцээний цагаар сонгуулийн сурталчилгааг гаргахдаа редакцийн мэдээний шударга, тэнцвэртэй, хараат бус байдлыг хангах тухай зохицуулалтыг хууль, эрх зүйн орчинд нарийвчлан судлал хэрэгтэй байна.

МУЕСХ-иар хориглосон мэдэгдэл, үүний дотор улс төрийн намын сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараавал хуулийн хариуцлагыг мэдээлийн хэрэгсэлд хүлээлгэхээр уг хуулинд заажээ. ШӨХТГ хэвлэл мэдээлэлтэй холбоотой хэд хэдэн өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд нэг тохиолдлыг дурдвал нэр дэвшигч Б.Бат-Эрдэнийн сонгуулийн сурталчилгааны урианы үгийг санаатайгаар үсэг өөрчлөн гуйвуулсан сэтгүүлчдэд торгууль ногдуулсан байна.⁵³

Хуулийн зохицуулалтаар хариуцлагыг дамжуулсан мэдээллийн хэрэгсэл биш харин улс төрийн сурталчилгаа буюу уриа бичлэг гаргасан улс төрч холбоотой хүлээлгэх зохицуулалтыг хуулинд тусгах.

С ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны хэвлэл мэдээллийн МОНИТОРИНГ



ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ нь сонгуулийн сурталчилгааны албан ёсны хугацаанд 5 телевиз, 4 сонинд тоон болон чанарын мониторинг хийсэн.⁵⁴ Мониторинг хийгдсэн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд төлбөртэй болон төлбөргүй сурталчилгааг хуулийн дагуу гурван нэр дэвшигчдэд тэнцүү хэмжээгээр явуулсаныг САХ-ны мониторингийн үр дүн баталж байна.

Гэхдээ мэдээний хөтөлбөрөөр сонгуулийн сурталчилгаа ихээхэн хязгаартай гарсан.⁵⁵ Сонгуульд өрсөлдөгчдийн бүх телевизүүдээр гаргасан сурталчилгаанууд эерэг эсвэл төвийг сахисан өнгө аястай байсан. МҮОНТ болон арилжааны ТВ9 телевизээр гарсан мэдээний хөтөлбөрөөр нэр дэвшигчдийн сурталчилгааг тэнцвэртэй гаргасан. МҮОНТ-ийн мэдээний хөтөлбөрийн 31 хувийг Б.Бат-Эрдэнийн сурталчилгаанд, 36 хувийг Ц. Элбэгдоржийн, 33 хувийг Н. Удвалын сонгуулийн сурталчилгаа эзэлжээ. ТВ9 телевизийн хувьд Б. Бат-Эрдэнэ, Ц. Элбэгдорж нарт тус тусад нь 32 хувь, Н. Удвалд 36 хувийг тэдний сурталчилгаанд зориулжээ. Тэгвэл эсрэгээр, одоогийн Ерөнхийлөгчийн талаар Йигл болон ТВ5 телевизүүд илүү сурталчилжээ. Йигл-ээр Ц. Элбэгдоржийн тухай 55 хувь, Б. Бат-Эрдэнийн тухай 26 хувь, Н. Удвалын тухай 19 хувь мэдээлэл тус тус гарчээ. ТВ5 мөн ийм байдалтай гаргасан ба Ц. Элбэгдоржид 43 хувь, Б. Бат-Эрдэнэд 29 хувь, Н. Удвалд 28 хувийг зориулжээ.⁵⁶ UBS ТВ-ийн хувьд хуулиар мэдээний хөтөлбөрөөр сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглосон

⁵³ “Бид Эвийг эрхэмлэнэ, Зөвийг дэмжинэ” гэдэг сонгуулийн уриаг “Эдийг эрхэмлэнэ” болгож өөрчилсөн. Үүнийг санаатай хийсэн үйлдэл гэж ШӨХТГ үзжээ. Учир нь энэ үсгийн алдааг ам болон бичгийн аль алианаар нь гаргасан байсан.

⁵⁴ ЕАБХАБ-ын АИХЭГ нь 5 дугаар сарын 22-ноос эхлэн МҮОНТ, Йигл ТВ, ТВ5, ТВ9 болон UBS телевизүүд болон *Өдрийн сонин*, *Үнэн*, *Өнөөдөр*, *Зууны мэдээ* сонинуудад мониторинг хийсэн.

⁵⁵ МҮОНТ-ын хувьд сонгуулийн сурталчилгааны бүх хугацаанд 5 дугаар сарын 22-ноос 6 дугаар сарын 14-ны хооронд гурван нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааг нийт 3 цаг 20 минутын хугацаанд явуулжээ. Арилжааны телевизүүд нэлээн бага хугацаагаар гаргасан байна. Йигл ТВ-1 цаг 46 минут, ТВ5-ойролцоогоор 1 цаг, ТВ9-36 минут.

⁵⁶ Эдгээр тоо хэмжээнд байгууллагын зүгээс гаргах үүрэг бүхий мэдээлэл ороогүй зөвхөн мэдээний хөтөлбөрөөр гарсан сонгуулийн сурталчилгаа хамаарч байгаа болно.

гэж ойлгож байсан тул мэдээнийхээ хөтөлбөрөөр сонгуулийн сурталчилгаа явуулаагүй байна. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ нь мониторинг хийсэн сонингууд дээр гарсан сурталчилгааны хэмжээг харуулсан.⁵⁷ Өдрийн сонин Ц. Элбэгдоржийн сурталчилгааг түлхүү гаргасан бол *Үнэн* Б. Бат-Эрдэнийг, *Зууны мэдээ* Н. Удвалыг илүү сурталчилсан байна.

Мониторинг хийсэн бүх телевизүүдээр цаг үеийн үйл явдал болон хэлэлцүүлгийн нэвтрүүлэгүүд тогтмол гарж байсан хэдий ч нэр дэвшигчдийн дунд зөвхөн ганцхан мэтгэлцээнийг 6 дугаар сарын 24-ны өдөр явуулсан. Сэтгүүлчид, шинжээчид болон олон нийт өөрсдийн сонирхсон асуултуудаа нэр дэвшигчдээс асуух, мөн түүнчлэн нэр дэвшигчид хоорондоо мэтгэлцэх боломж олгох нэвтрүүлгүүд бараг байсангүй. Энэ байдал нь хэвлэл мэдээллийнхэнд өөрсдийн чиг үүргээ биелүүлэн сонгуулийн асуудлаар болон улс төрийн сонголтуудын талаар ул суурьтай, хүчтэй олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх боломж олгосонгүй төдийгүй сонгогчид мэдээллээр сайн хангагдах замаар шийдвэр гаргах үйл явцад хувь нэмэр оруулах, оролцох чадварт нь сөргөөр нөлөөлсөн.

XI. ИРГЭН БА ОЛОН УЛСЫН АЖИГЛАГЧИД

МУЕСХ-иар дотоодын болон олон улсын ажиглалт хийхийг зөвшөөрдөг. Гэхдээ уг хууль болон СЕХ-ны 2013 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 15 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг ажиглах журам”-ын аль нь ч сонгуулийн үйл ажиллагааг бүхэлд нь ажиглах боломжоор хангаагүй байна. Улс төрийн нам, эвсэл, ТББ-ын зүгээс 4 хүртэлх ажиглагчийг томилж СХХ-нд ажиглалт хийлгэх эрхтэй. Энэ удаагийн сонгуулийн үеэр дотоодын ажиглалтыг голдуу нам болон нэр дэвшигчийн ажиглагчид хийлээ. Иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийн санал авах өдрөөс өмнөх үеийг ажиглаагүй юм. Энэ нь нэг талаар санхүүгийн боломжгүй байдал, нөгөө талаас сонгуулийн санал авах өдрөөс өмнөх хугацаанд мониторинг хийхийг хязгаарласан СЕХ-ны шийдвэртэй холбоотой.⁵⁸ Сонгуулийн санал авах өдөр ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны ажиглалт хийсэн СХХ-ны санал авах байрнуудад ажиглагч иргэдийн тоо хязгаартай байлаа.

Дотоодын болон гадаадын ажиглагчдыг сонгуулийн явцыг бүхэлд ажиглах боломжоор хангах зохицуулалтыг сонгуулийн хууль тогтоомжинд тусгах. Сонгуулийн өмнө болон санал авах өдөр ажиглалт хийх эрх олгох тухай салангид журам болон дуусах хугацааны асуудлыг авч үзэх нь зүйтэй. Түүнчлэн сонгууль болохоос өмнө тодорхой цаг хугацаа хүртэл сонгуулийн ажиглалт хийх эрх олгох.

XII. ӨРГӨДӨЛ ГОМДОЛ

Өргөдөл, гомдолтой холбоотой асуудлыг ерөнхийд нь МУЕСХ-иар зохицуулах ба хариуцлага тооцох нэг шатлалт бүтцийг тогтоогүй байна. Түүнчлэн, сонгуулийн маргааныг бусад хуулиар, үүний дотор Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний болон Эрүүгийн хуулиуд, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулиудаар зохицуулж байна.

⁵⁷

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хийсэн мониторингийн үр дүнг Эцсийн тайлангийн хавсралтаас үзнэ үү.

⁵⁸

СЕХ-ны 23 дугаарт шийдвэрийн 2.2 зүйлд “ТББ-ууд сонгуулийн санал авах өдөр зарлагдсанаас хойш 15 өдрийн дотор сонгуульд хяналт тавих хүсэлтээ бичгээр гаргах ” гэж заасан (жишээлбэл: сонгуулийн санал авах өдрөөс 50 хоногийн өмнө).

Сонгуультай холбоотой өргөдөл, гомдлыг хэд хэдэн шүүх, төрийн байгууллагууд харьяаллаараа хянан шийдвэрлэж байна. Сонгуулийн хорооны шийдвэрийн эсрэг гомдлыг дээд шатных нь сонгуулийн хороонд гаргаж болох бөгөөд дээд шатны сонгуулийн хороо гурав хоногийн дотор шийдэх ёстой. Нэг бол Захиргааны хэргийн шүүхэд хандаж болно (СЕХ-ны шийдвэрээс бусад шийдвэрийн эсрэг).⁵⁹ Энэ асуудлаар МУЕСХ-нд заагаагүй ч СЕХ-ноос ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-нд мэдээлсэнээр бол СЕХ-ны шийдвэрийн талаарх гомдлыг Чингэлтэй дүүргийн шүүх, цаашлаад Улсын Дээд шүүхэд, хэрэв СЕХ-ны шийдвэр Үндсэн хуулийг зөрчсөн хэмээн үзвэл гомдлыг Үндсэн хуулийн цэцэд гаргах эрхтэй. Үндсэн хуулийн цэц нь зөвхөн СЕХ-ны бичгээр гаргасан шийдвэрийн эсрэг иргэнээс гаргасан гомдлыг хүлээж авдаг. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой гомдлыг ШӨХТГ шийдвэрлэнэ.⁶⁰ Сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гомдлыг Иргэний бүртгэл хариуцсан холбогдох байгууллага авч үзэх ба, УБЕГ-ын шийдвэрийн эсрэг гомдлыг Захиргааны хэргийн шүүхэд гаргаж болно. МУЕСХ-нд зааснаар хууль зөрчсөн талаарх бусад бүх өргөдөл гомдлыг цагдаагийн байгууллага шалгах ба шалгалт дээр үндэслэн харъяа орон нутгийн шүүх шийдвэрлэнэ. Шүүхийн эрх мэдлийг зохицуулах хуулиудын дагуу сонгуультай холбоотой гомдлыг дээд шатных нь шүүхэд гаргаж болох ба гомдлыг хуулиар тогтоосон хугацаанд шийдвэрлэх ёстой.⁶¹ Шүүхэд гомдол гаргасан тохиолдолд хянан шийдвэрлэх хугацаа нь хэд хэдэн сар болох магадлалтай тул ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагены баримт бичгийн 5.10-т заасан шаардлагын дагуу гомдлыг сонгуулийн хугацаанд багтаан хурдан шуурхай, үр дүнтэй шийдвэрлэх зарчмыг хэрэгжүүлэх боломжгүй байна.⁶²

Хэд хэдэн байгууллага сонгуулийн маргааныг харьяалж, хянан шийдвэрлэх эрхтэй байгаа, эдгээр байгууллагуудын сонгуультай холбоотой хөндөгдсөн эрхийг сэргээх дээр нь эрх мэдлийнх нь хүрээг хуулиар нарийн зохицуулаагүй байгаа нь ЕАБХАБ-ын зарчим, олон улсын сайн туршлагатай нийцэхгүй байна.⁶³ Цаашилбал оролцогч талууд сонгуулийн маргаан шийдвэрлэх үйл явц дээр нэгдмэл ойлголтгүй, энэхүү үйл явцын тухай тайлбар нэг мөр биш байв. Сонгуультай холбоотой гомдол гарсан тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагууд шударга, үр дүнтэй ажиллаж чадах эсэх дээр улс төрийн нэг нам эргэлзэж байсан.

⁵⁹ Үндсэн хуулийн цэцийн 2005 оны шийдвэрийн дагуу Захиргааны хэргийн шүүхээр СЕХ-ны эрх зүйн акт, шийдвэрийг хянан шийдвэрлэхээ болисон. Захиргааны хэргийн шүүхээр АНСХ, СДСХ болон СХХ-ны шийдвэрийг хянах шийдвэрлэнэ.

⁶⁰ Хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэсэн Х-аар хэсгийг харна уу.

⁶¹ Иргэний болон эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуульд заасны дагуу шүүх хэргийг 60 хоногт багтаан хянан шийдвэрлэх ба давж заалдах гомдол гарсан хэргийг шүүх хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ. Цаашлаад 7-14 хоногийн хугацаанд мөрдөн шалгана. Эдгээр хуулийн хугацаанаас болоод өнөөдрийг хүртэл цагдаагийн байгууллагаар шалгагдсан өргөдөл гомдлоос шүүхэд хянан шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн хэрэг байхгүй байна. Сонгуультай холбоотой эрүүгийн шинжтэй хэдхэн хэрэгт хялбаршуулсан журмаар эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэдэг.

⁶² ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагены баримт бичгийн 5.10-т “захиргааны шийдвэрийн эсрэг авч хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэрэгслийг” хүн бүр эрэлхийлэх эрхтэй ба “ингэснээр үндсэн эрхийг хүндлэн дээдлэх зарчмыг баталгаажуулах ба хууль эрх зүйн шударга байдлыг хангана” гэж заасан.

⁶³ ЕАБХАБ-ын 1991 оны Москвагийн баримт бичгийн 18 дугаар хэсэгт ЕАБХАБ-ын бүрэн эрхт гишүүн орнуудын “захиргааны шийдвэрийн эсрэг авч хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэрэгслээр хангах” үүрэгтэй гэж заасан. Венецийн комиссийн Сонгуультай холбоотой асуудлууд дахь сайн туршлагын тухай зааврын 3.3(с) заалтыг үзнэ үү. Үүний 11-р хуудсанд “Өргөдөл гомдол гаргах журам, ялангуяа эрх бүхий этгээдийн эрх мэдэл, үүрэг хариуцлагыг хуулиар сайн зохицуулах хэрэгтэй. Ингэснээр шүүх эрх мэдэл хэрэгжих газар нутгын талаарх маргаан, зөрчилдөөнөөс зайлсхийх (эсрэг эсвэл сөрөг байдлаар) ба Өргөдөл гомдол гаргагч, эрх бүхий байгууллагын аль нь ч гомдол гаргах байгууллагыг сонгохгүй” гэж заасан ба үүнийг [http://www.venice.coe.int/docs/2002/CDL-AD\(2002\)023-e.pdf](http://www.venice.coe.int/docs/2002/CDL-AD(2002)023-e.pdf) -ыг үзнэ үү.

Өргөдөл, гомдлын үйл явцыг зохицуулах хуулийн заалтуудыг нэгтгэх, харъяаллын давхардалтыг арилгах, нэг шатлалт систем байгуулах замаар сонгуулийн маргаан хянан шийдвэрлэх явцыг хялбарчилах, түүнчлэн өргөдөл гомдлыг цаг алдалгүй шийдвэрлэхийн тулд сонгуулийн хууль тогтоомжийг хянаж, нэмэлт өөрчлөлт оруулах.

ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-нд мэдээлсэнээр сонгуультай холбоотой 73 гомдлыг өөр өөр байгууллагад гаргажээ. Тухайлбал, СЕХ, доод шатны сонгуулийн хороо, цагдаа, ШӨХТГ, аймгийг Засаг дарга, эсвэл Иргэдийн төлөөлөгчдийн хуралд сонгуультай холбоотой гомдлыг шийдвэрлүүлэхээр ханджээ. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-ны хүлээн авсан өөр нэг мэдээлэл бол АНСХ-ны дарга МУЕСХ-ийн шаардлагын дагуу АНСХ-ны уулзалтын тухай нийтэд мэдэгдэх байсан хэдий ч мэдээлээгүй гэсэн гомдлыг Дархан-Уул аймгийн сум дундын шүүхээр шийдвэрлэсэн хэрэг юм.

ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ нь цагдаа эсвэл Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газар (ШӨХТГ)-т ирсэн өргөдөл гомдолтой танилцах боломжоор хангагдаагүй, мөн СЕХ-нд ирсэн бүх өргөдөл гомдолтой бүрэн танилцах боломжоор хангагдаагүй болно. СЕХ хүлээн авсан өргөдөл, гомдлынхоо заримыг хураангуй эсвэл хуулбар байдлаар ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-нд өгсөн хэдий ч, өргөдөл, гомдолтой бүрэн танилцах тухай тус САХ-ноос гаргасан хүсэлтийг татгалзсан. СЕХ-нд ирүүлсэн гомдлуудын ихэнх нь сонгуулийн хороонуудын бүрэлдэхүүнтэй холбоотой байв. СЕХ эдгээр гомдлыг барагдуулсан байдал дээр МАН шүүмжлэлтэй хандаж, СЕХ-ны шийдвэрүүдээ хараат байдлаар гаргалаа гэсэн.⁶⁴ Цагдаагийн байгууллага болон ШӨХТГ-т ирсэн олон гомдлуудын хуулбарыг СЕХ-нд хүргэсэн байсан бөгөөд сонгуулийн сурталчилгаатай холбоотой хуулийн заалтыг зөрчсөн тухай байв. Шийдвэрийг хэрхэн гаргасаныг баталгаажуулах боломж ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-нд байсангүй. Нийслэлийн прокурор болон Ерөнхий прокурорын төлөөлөгчид санал авах өдрийн өмнө ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-той уулзаж, мэдээлэл өгөхийг зөвшөөрсөн. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ нь аймгуудаас ирсэн 4 гомдол, Нийслэлийн цагдаагийн газраар мөрдөн шалгуулахаар ирсэн 12 хэргийг л хүлээн авсан. Энэ 12 хэргийн нэгийг бүрэн мөрдөн байцаалтанд шилжүүлсэн байсан.⁶⁵

Сонгуулийн үйл явцад итгэх олон нийтийн итгэлийг хадгалах, ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд сонгогчдоос ирсэн өргөдөл, гомдол, түүнчлэн гомдлын мөрөөр хийсэн шалгалт, шийдвэрийн дэлгэрэнгүйтэй танилцах боломжоор олон нийтийг хангах талын арга хэмжээг авах.

ХИИ. САНАЛ АВАХ ӨДӨР

ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ нь санал авах өдрийн үйл явцад ажиглалт хийлгэхээр бүрэн эрхт гишүүн 33 орноос ирсэн 210 олон улсын ажиглагчдыг санал авах өдөр тараан байрлуулсан. САХ-ны ажиглагчид 16 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт ажиглалт явуулсан. Тэд зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авахтай холбоотой 70

⁶⁴ Нийт 39 гомдол сонгуулийн хороонуудын бүрэлдэхүүнтэй холбоотой байна. СЕХ сонгуулийн хороонуудын гишүүнээр батлагдсан хүмүүсийн жагсаалтыг багтаасан тогтоолоор энэхүү асуултанд хариулсан ба ямар үндэслэлээр бусад хүмүүсийг сонгохоос татгалзсан болох, гишүүнээр сонгогдсон хүмүүст ямар шалгуур тависан болохыг дурдаагүй байна. Бусад хариултууд гомдлын гол мөн чанар, агуулгад хамааралгүй байсан ба нэг хариултанд СЕХ-ны бүрэн эрхийн хүрээнд байгаа асуудлуудад хөндлөнгөөс оролцохоо зогсоохыг хүссэн байв.

⁶⁵ ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон САХ-нь нэмэлт мэдээлэл хүссэн бүх хүсэлтэндээ хариу авч чадаагүй ба САХ-г бусад байгууллага руу ханд гэсэн хариу өгсөн.

тайлан, санал авах байрнуудын нээлттэй холбоотой 72 тайлан, санал өгөх ажиллагаатай холбоотой 753 (659 санал авах байрнаас авсан) тайлан, санал тоолохтой холбоотой 85 тайлан, сонгуулийн материалыг боловсруулах болон 35 СДСХ-ны хүснэгт эд оруулах үйл явцын тухай 63 тайланг тус тус хүргүүлсэн. Сонгуулийн санал авах өдөр амгалан тайван болж өнгөрсөн ба СЕХ-ны мэдээлснээр сонгуулийн ирц 66.5 хувьтай байлаа. ЕАБХАБ-ын АИХЭГ-ын ажиглагчид санал авах өдрийн тухай журмын тэгш бус хэрэгжилтийн тохиолдлуудыг тэмдэглэсэн. Энэ нь сонгуулийн хороонуудын ажлыг зохицуулах дүрэм, журам дутмагаас болж байгаа байх.

А ЗӨӨРИЙН БИТҮҮМЖИЛСЭН САНАЛЫН ХАЙРЦГААР САНАЛ ӨГӨХ

ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-ны ажиглагчид зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх 70 тохиолдлыг ажигласан ба тэдний 66-г нь эерэгээр үнэлсэн. Сонгогчдын иргэний үнэмлэхийг шалгах журам ерөнхийдөө хэрэгжсэн. Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх явцад асуудал гарч байсан ба үүнд зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгыг зохих ёсоор лацдаагүй 1 тохиолдол, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгыг шөнө аюулгүй газар хадгалаагүй 1 тохиолдол, СХХ дээр сонгогчдод мэдээллийн материалыг үзүүлээгүй 10 тохиолдлыг багтаана. Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх явцад гарсан хамгийн гол асуудал бол сонгууль өгөх нууцлалын асуудал юм. 29 тохиолдолд нууцлал тогтмол хангагдаагүй.

В САНАЛ АВАХ БАЙРНЫ НЭЭЛТ БОЛОН САНАЛ ӨГӨХ

ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-ны ажиглагчдын ажиглалт хийсэн 72 хэсгийн хорооны 3-аас бусад хэсгийн хорооны нээлтийн үйл явцыг эерэгээр дүгнэлээ. МҮЕСХ-иар сонгогчид саналаа өгч эхлэх болон СХХ сүүлчийн бэлтгэл ажлаа хангахаар уулзах цаг хугацааг хоёуланг нь өглөөний 07.00 цаг гэж тогтоосноос болж ажиглалт хийгдсэн санал авах байрнуудын 42 нь цагтаа нээгдээгүй болно.

Санал өгөх цаг эхэлхээс өмнө санал хураах өдөрт зориулан хийсэн эцсийн бэлтгэлийг СХХ-д дүгнэх боломж олгох зохицуулалтыг МҮЕСХ-д нэмэлт өөрчлөлтөөр оруулах.

Ажиглалт хийгдсэн санал авах байрнуудад явуулсан санал өгөх үйл ажиллагааны 99 хувь нь эерэг үнэлгээ авсан (76 хувь нь их сайн, 23 хувь нь сайн үнэлгээ авсан) ба ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-ны ажиглагчдын ажигласан СХХ-ны санал авах байрнуудын зөвхөн 8 нь сөрөг үнэлгээ авсан. Холбогдох процедурыг ерөнхийдөө дагаж мөрдсөн боловч сонгогч нууцаар саналаа гаргах боломж зуун хувь хангагдаагүй (10 хувь). Учир нь сонгогчид саналын хуудсаа бүхээгт орж тэмдэглэсэн ч тэндээсээ СТАТ-нд хийх үед тэмдэглэсэн саналын хуудсаа хамгаалахгүй байх тохиолдлууд гарч байсан.⁶⁶

Саналын хуудас, түүнчлэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах үеийн нууцлалыг хамгаалах нэмэлт арга хэмжээ авах, СХХ-нуудад зориулсан нэмэлт сургалт, заавар, түүнчлэн сонгогчийн боловсролыг нэмэгдүүлэх.

ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-ны ажиглагчид журмын маш цөөхөн ноцтой зөрчлийг тэмдэглэсэн. Эдгээр зөрчилд бүлгээр санал өгөх (17 хэрэг), итгэмжлэлээр санал өгөх болон сонгогчдод нөлөөлөхийг завдах (тус бүрдээ 3, 3 хэрэг), олон удаа санал өгөх, сонгогчдын нэрийн жагсаалт дээрхтэй илт төстэй цуврал гарын үсэг (тус бүрдээ 2, 2 хэрэг) гэсэн

⁶⁶

Тэмдэглэсэн саналаа хаах зориулалттай хаалтыг бүхээг бүрт тавиагүй байх тохиолдол байсан, түүнээс гадна хаалтаар хангагдсан хэдий ч сонгогчид хэрэглэхгүй тохиолдол байлаа.

зөрчлүүд багтана. Цөөн хэдэн хийдлийг эс тооцвол иргэний бүртгэлийн мэдээллийг шалгах болон хурууны хээ уншуулах ажил журмын дагуу явагдсан ба ажиглалт хийгдсэн сонгуулийн санал авах байрнуудаас таван хувьд нь зарим сонгогчид сонгогчдын нэрийн жагсаалтанд нэр нь байхгүйгээс болж саналаа өгч чадалгүй буцаж байв. ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-ны ажиглагчид хурууны хээ уншуулах төхөөрөмж болон СТАТ-тэй холбоотойгоор гарсан техникийн асуудлуудын талаар үе үе мэдээлж байсан ба энэ асуудал нь сонгуулийн үйл явцад ноцтой сөрөг нөлөө үзүүлээгүй болно.⁶⁷

СХХ-ны гишүүдийн 77 хувь нь эмэгтэй ба ажиглалт хийгдсэн сонгуулийн санал авах байрнуудын дарга нарын 56 хувь нь эмэгтэй хүн байлаа. Ажиглалт хийгдсэн сонгуулийн санал авах бараг бүх байранд нэр дэвшигчдийн төлөөлөгчид байсан ба ажиглагч иргэд 11 хувийг эзэлж байв. Ажиглалт хийгдсэн сонгуулийн санал авах байрнуудын цөөн тоонх (хоёр хувь) нь зай муутай, сонгогчид ихээр чихэлдэж байсан нь сонгогчид саналаа өгөхөд тохиромжгүй байв. Хэдийгээр МУЕСХ-иар шаардаж байгаа ч сонгуулийн санал авах байрнуудын талаас дээшид нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан байгууламж бэлэн болоогүй байсан бөгөөд санал авах байрнуудын 26 хувь эдгээр сонгогчдод тохиромжгүй байдлаар засагдсан байв. Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтсаар олон удаа хангах боломжгүй байлаа.⁶⁸

СЕХ болон эрх бүхий бусад холбогдох байгууллагууд санал авах байрнуудад хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын нэвтрэх боломжийг хөнгөвчлөхийн тулд шаардлагатай арга хэмжээг тогтоох, батлах, үүний дотор шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль тогтоомжинд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор дахин нягталж үзэх. Энэ ажилд хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдыг оролцуулах.

С САНАЛ ТООЛОХ БА ХҮСНЭГТЛЭХ

ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-ны ажиглагчид ажиглалт хийсэн 80 сонгуулийн хэсгийн хорооны 14-өөс бусдад нь сонгуулийн санал тоолох ажлын үйл явцыг эерэгээр дүгнэлээ. ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-ны ажиглагчид процедурын зарим нэг зөрчлийг, жишээлбэл СХХ-нууд журамд заасан бүх дарааллыг баримтлахгүй байсныг тэмдэглэсэн. Хурууны хээгээ уншуулж, цахим иргэний үнэмлэхнийхээ мэдээллийг шалгуулан баталгаажуулсан сонгогчдын тоог олгосон болон санал өгсөн саналын хуудастай тулгахыг хуулиар шаардаагүй болно. Ийм тулгалт хийвэл боломжит зөрчлөөс хамгаалах нэмэлт хамгаалалт болж чадах байв. МУЕСХ-иар СТАТ-ийн тайлангийн/үр дүнгийн хуулбарыг авах эрхийг ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-ны ажиглагчид эдлэх ёстой ч тайлангийн хуулбарыг тэдэнд тогтмол өгөөгүй болно.⁶⁹ Автоматаар болон гар аргаар саналын хуудас тоолох журмын хэрэгжилтийг санал авах 16 байранд ажигласан бөгөөд ихэнхи байранд тооллогын үр дүн зөрөөгүй. Ажиглалт хийгдсэн 21 тооллогын үеэр СХХ-нууд протоколоо тэмдэглэж дуусахад бэрхшээл тулгарч байсан ба ийм 5 тохиолдол гарсан. Автомат болон гар аргаар тоолсон тооллогын хооронд гарсан зөрүү нь СТАТ хүчингүй саналын хуудсыг зохих ёсоор тоолоогүйтэй холбоотой. Материал болон протоколыг СДСХ-нд нэн даруй зөөгөөгүй 15 тохиолдол гарсан.

⁶⁷ Жишээлбэл, сонгогчын хурууны хээг унших төхөөрөмж сонгогчийн хурууны хээг уншихгүй тохиолдолд түүний иргэний үнэмлэхний дугаарыг шивж оруулан тухайн хүнийг таньж байлаа.

⁶⁸ ХБИЭК -ийн 19-р зүйлд “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад хүмүүсийн нэгэн адил улс төр болон нийтийн амьдралд шууд эсвэл чөлөөтэй сонгох зарчмаар сонгогдсон төлөөллөөрөө дамжуулан тэгш оролцох, үүний дотор хөгжлийн бэрхшээлтэй иргэний санал өгөх, сонгогдох эрх болон боломж”-оор хангах үүргийг тусгажээ.

⁶⁹ МУЕСХ-ийн 50-р зүйл, СЕХ-ны 15 дугаар тогтоолын 4-р зүйл.

СДСХ-ны хүснэгт гаргах үйл явцыг ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-ны ажиглагчид сонгуулийн санал авах 63 байран дээр ажигласан ба тэдгээрийн 20 нь зохион байгуулалт, ил тод бус байдлаасаа болж сөрөг үнэлгээ авсан. Ажиглалт хийгдсэн СХХ-ны санал авах байрнуудын тал нь сонгогчдыг хүлээн авах болон үйл ажиллагаа явуулахад тохиромжгүй байсантай холбоотой бөгөөд хүмүүсийн чихэлдээн сонгуулийн үйл явцад сөрөг нөлөө үзүүлсэн 23 тохиолдлыг САХ-ны ажиглагчид тэмдэглэсэн. Үймэх, дайрах 4 тохиолдлыг тэмдэглэсэн.

СДСХ-нуудад процедурыг дийлэнхдээ дагаж мөрдөж байсан боловч СХХ-дын протокол хөтлөлттэй холбоотой зарим асуудлыг, тухайлбал бүрэн гүйцэд хөтлөхгүй байх, буруу бөглөх зэргийг ажиглагчид анзаарсан байна. СДСХ протоколын тоог өөрчилсөн 11 тохиолдол гарсан ба үүнээс 6 нь арифметикийн алдаа байв. Процедурын томоохон алдааны 6 тохиолдлыг тэмдэглэсэн. СДСХ-той бүрэн хамтран ажиллаагүй тул зарим нэг ажиглагчдын ажиглалтыг хязгаарласан 9 тохиолдлыг тэмдэглэсэн.

ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-ны УХА-чид хязгаарлагдмал тоотой АНСХ-ны хүлээлгэн өгөх болон хүснэгт гаргах үйл явцыг ажигласан ба энэ ажлууд ерөнхийдөө дэг журамтай, сайн зохион байгуулагдсан. СЕХ-ны мэдээлсэнээр СТАТ-өөс хүлээн авсан мэдээн дээр үндэслэсэн АНСХ-ны түвшинд нэгтгэсэн үр дүн болон СХХ-ны цаасаар үйлдсэн протокол дээр үндэслэн гаргасан үр дүн хоёрын хооронд зөрүү гараагүй байна.

D СОНГУУЛИЙН ҮР ДҮН, ТҮҮНИЙГ ЗАРЛАХ

СЕХ нь бүх 1,896 СХХ-ны СТАТ-өөс авсан үр дүн дээр үндэслэсэн сонгуулийн урьдчилсан үр дүнг 2013 оны 6-р сарын 27-ны өдөр өөрийн байгууллагын цахим хуудаснаа тависан. Урьдчилсан дүнг СХХ-ны түвшинд бус нийслэл хот болон аймгуудын түвшинд гаргасан. Гадаадад өгсөн саналын үр дүнг СЕХ санал авах өдрийн 22:00 цагт тогтоосон байсан ч 6-р сарын 27-ны өдөр л нийтэд ил болгосон.

Ерөнхийлөгчийн сонгуулийн эцсийн үр дүнг ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-нд 7 дугаар сарын 2-нд хүлээлгэн өгсөн ба 7 дугаар сарын 4-ны өдөр СЕХ-ны цахим хуудсан дээр байрлуулан олон нийтэд ил болгосон ба энэ удаад ч бас АНСХ болон нийслэл хотын дүүргүүдийн түвшинд гаргажээ.⁷⁰ СТАТ-ийн алдаатай программаас болж СЕХ-ны нийтэлсэн үр дүнд хүчингүй саналын хуудасны тоо ороогүй. Хүчингүй саналын тоо нь нэр дэвшигчдийн төлөө өгсөн саналын хуудасны тоо болон хоосон саналын хуудсыг сонгогчдод олгосон нийт саналын хуудаснаас хасах замаар л гаргаж ирнэ.⁷¹

Санал авах байр нэг бүрийн сонгуулийн үр дүнг АНСХ, СДСХ, болон СЕХ-ны бүх протокол болон хүснэгтийн хураангуйтай хамт СЕХ-ны цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээр цаг алдалгүй нийтлэх хуулийн шаардлагыг нэвтрүүлэх талаар авч үзэх.

СЕХ нь парламентаар батлагдах Ерөнхийлөгчийг томилох тухай шийдвэрийн төсөлд сонгуулийн эцсийн үр дүнг хавсарган парламентад илгээсэн. Парламент Ц. Элбэгдоржийн бүрэн эрхийг чуулганаараа хүлээн зөвшөөрсөн ба албан ёсны ёслолын ажиллагаа нь 7 дугаар сарын 10 өдөр зохион байгуулагдсан.

⁷⁰ Сонгуулийн үр дүнг хавсралтаас үзнэ үү.

⁷¹ ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ-ны тооцоолсоноор хүчингүй болсон саналын хуудсын тоог 2,359 буюу санал өгсөн бүх саналын хуудасны 0.19 хувь байсан.

XIV. ЗӨВЛӨМЖ

ЕАБХАБ-ын үүрэг амлалт, ардчилсан сонгуулийн төлөө бусад стандартуудад нийцсэн сонгууль явуулахын төлөө Монгол Улсын эрх бүхий байгууллагууд, улс төрийн намууд болон иргэний нийгмийн зүгээс гаргах цаашдын хүчин чармайлтанд дэмжлэг үзүүлэх үүднээс доорхи саналыг дэвшүүлж байна. Сонгуулийн үйл явцыг цаашид сайжруулахын тулд Монголын эрх бүхий байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллагуудад ЕАБХАБ-ын АИХЭГ тусламж, дэмжлэг үзүүлэхэд бэлэн байна.

А НЭН ТЭРГҮҮНИЙ ЗӨВЛӨМЖҮҮД

1. 1990 оны ЕАБХАБ-ын Копенгагены баримт бичгийн 7.5 дахь хэсэг, мөн ардчилсан сонгуулийн төлөөх олон улсын стандартын нэр дэвшигчийг гарал угсаагаар ялгахгүй байх тухай шаардлагын дагуу холбогдох хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах, түүнчлэн эх орондоо байнга оршин суух тухай шаардлагыг дахин харгалзаж үзэх нь зүйтэй.
2. Өргөдөл, гомдлын үйл явцыг зохицуулах хуулийн заалтуудыг нэгтгэх, харъяаллын давхардалтыг арилгах, нэг шатлалт систем байгуулах замаар сонгуулийн маргаан хянан шийдвэрлэх явцыг хялбарчилах, түүнчлэн өргөдөл гомдлыг цаг алдалгүй шийдвэрлэхийн тулд сонгуулийн хууль тогтоомжийг хянаж, нэмэлт өөрчлөлт оруулах.
3. Үйлдсэн гэмт хэргийнх нь хүнд хөнгөнөөс үл хамааран хорих газар ял эдэлж байгаа иргэний сонгуульд оролцох эрхийг хязгаарлаж байгааг оногдуулсан хязгаарлалт болон хэргийн хүнд хөнгөний хоорондын тэнцүү чанарыг хангах үүднээс дахин авч үзэх нь зүйтэй.
4. Сонгуулийн байгууллагад итгэх итгэлийг хадгалах үүднээс МУЕСХ болон СЕХ-ноос гаргасан дүрэм журамд сонгуулийн хорооны гишүүнд нэр дэвших төрийн албан хаагчид тавих шалгуурыг улам нарийвчлан тусгах нь зүйтэй.
5. Доод шатны сонгуулийн хороодын ажилд зориулсан иж бүрэн дүрэм журмыг СЕХ-гоор батлуулах шаардлагыг МУЕСХ-нд тусгах нь зүйтэй. Үүнд сонгуулийн санал авах өдөр ажиллах журам, ялангуяа сонгогчдын нэрийн жагсаалтанд дээр гарын үсэг зурсан сонгогчдын тоог болон санал авсан саналын хуудастай тулгах, санал авах байрнуудын дотор дүрс бичлэгийн камер суурилуулах, дүрс бичлэгийг өргөдөл, гомдолыг хянан шийдвэрлэхэд ашиглах болон сонгуулийн үр дүнгийн хурлын тэмдэглэлийг олон нийтэд зориулан санал авах байрнуудад ил тавих.
6. СЕХ, СТАТ нийлүүлсэн компанийн хамтын ажиллагаатайгаар уг төхөөрөмж сонгуулийн дүн, түүний дотор хүчингүй саналын хуудсын тоог багтаасан мэдээ тайланг үнэн зөв гаргах асуудлыг хангах. Түүнчлэн сонгуулийн өдрөөс нэлээн өмнө СТАТ-ийн үйл ажиллагаанд хөндлөнгийн буюу эрх бүхий гуравдагч талын үнэлгээ хийлгэн албан ёсны гэрчилгээ олгох үйл явцыг тогтоох. Ингэснээр СТАТ-ийг санал авах байрнуудад хүргэхээс өмнө болзошгүй алдааг засах боломжтой юм.
7. Мэдээний хөтөлбөр, хэлэлцүүлэг мэтгэлцээний үед олон нийтийн болон хувийн мэдээллийн хэрэгслээр явуулж байгаа сонгуулийн сурталчилгааг шудрага, тэнцвэртэй, хараат бус байдлыг хангахын тулд хууль эрх зүйн орчины зохицуулалтыг дахин авч үзэх нь зүйтэй.

8. Олон улсын холбогдох стандартын дагуу гүтгэх доромжлох хэргийг эрүүгийн хуулиар шийтгэх явдлыг цуцалж иргэний хуулиар шийдэх асуудлыг авч үзэх. Цаашлаад, гүтгэх, доромжлох хэрэгт иргэний хуулиар оногдуулах шийтгэл нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд сөргөөр нөлөөлөх хэмжээний их биш, харин нэхэмжлэгчид нөхөн олговор олгож, хариуцагчийг шийтгэх бус сэвтсэн нэр хүндийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг авах нь зүйтэй. Ялангуяа, учирсан бодит хохиролтой яг дүйцэх мөнгөн торгууль ногдуулах ба хуулиар мөнгөн бус зохицуулалтыг тэргүүн ээлжинд ашиглах нь зүйтэй.
9. Санал авах байр нэг бүрийн сонгуулийн үр дүнг АНСХ, СДСХ, болон СЕХ-ны бүх протокол болон хүснэгтийн хураангуйтай хамт СЕХ-ны цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээр цаг алдалгүй нийтлэх хуулийн шаардлагыг нэвтрүүлэх талаар авч үзэх.

В БУСАД ЗӨВЛӨМЖҮҮД

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

10. Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомжийг саяхан сайжруулсан хэдий ч зохицуулагдаагүй орхигдсон, хуулинд нийцэхгүй байгаа зүйлүүд байгаа тул үүнийг залруулах мөн ЕАБХАБ-ын үүрэг амлалт, ардчилсан сонгуулийн төлөөх олон улсын стандартуудыг дагаж мөрдөх үүднээс цаашид уг хуулийг хянаж үзэх.
11. Сонгуулийн хууль тогтоомжтой холбоотой аливаа хянан нягтлалтыг хийхдээ холбогдох бүх оролцогч талуудын, үүний дотор улс төрийн нам, иргэний нийгмийн төлөөллийг багтаасан өргөн оролцоотойгоор хийх.

СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА

12. Сонгуулийн байгууллагын хараат бус, бие даасан, ил тод байдлыг хуулиар хамгаалах болон уг байгууллагад итгэх илтгэлийг хадгалахтай холбоотой нэмэлт арга хэмжээг авах.
13. Ил тод байдлыг хангах, санал хураах шинэ технологи нь найдвартай гэдгийг батлахын тулд гар аргаар санал дахин тоолох СХХ-дыг санамсаргүй түүврийн аргаар сонгон авах процедурын баталгаа мөн гар аргаар болон машинаар тоолсон дүн зөрсөн тохиолдолд авах арга хэмжээг хуулинд тусгах асуудлыг авч үзэх.

СОНГОГЧИЙН БҮРТГЭЛ

14. Сонгогчид нэрийн жагсаалттай танилцан өөрсдийн бүртгэлээ баталгаажуулах эсвэл алдаатай байвал засуулахад хангалттай хугацаа олгох үүднээс сонгогчдын нэрийн жагсаалтыг 10 хоногийн турш албан ёсоор ил байлгах хугацааг дахин нягталж үзэх.
15. Хаягжилтын системийг боловсронгуй болгох, сонгогчийн нэрсийн жагсаалтыг үнэн зөв гаргах ажлыг сайжруулах үүднээс эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах.

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА

16. Сонгуулийн анхны санал хураалт болон хоёр дахь санал хураалтын хооронд, мөн дахин болон нэмэлт санал хураалт явуулах болсон тохиолдолд сонгуулийн сурталчилгаа явуулахыг МУЕСХ-нд зөвшөөрөх тухай нэмэлт өөрчлөлтийг оруулах.
17. ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагены баримт бичгийн 7.7-р зүйл заалтын шаардлагын дагуу улс төрийн намуудад сонгуулийн сурталчилгаагаа чөлөөтэй явуулах боломж олгохын тулд сонгуулийн сурталчилгаа явуулах журмын хязгаарлалтуудыг багасгах нэмэлт өөрчлөлтийг МУЕСХ-нд оруулах.

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ САНХҮҮЖИЛТ

18. СЕХ нь сонгуулийн сурталчилгааны санхүүжилтын ил тод байдал болон санхүүжилтын шударга байдалд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхийн тулд сонгуулийн сурталчилгааг санхүүжүүлэх тухай журмыг хугацаанд нь нийтлэх, сурталчилгааны санхүүжилтыг, үүний дотор сонгуулийн өмнөх үеийн санхүүжилтыг хянаж чадах ил тод, хэрэглэхэд үр дүн сайтай журмыг хэрэглэх.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

19. Цахим хуудсаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэтэрхий хязгаарлаж байгаа арга хэмжээнүүдийг зогсоох талаар анхаарч үзэх, цаашлаад хэрэглэгчийн бичсэн зүйлийн агуулгад мониторинг хийхийг интернэтийн зуучлагчид үүний дотор үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага болон бусад хүмүүсийн тависан материалыг эзэмшигчдээс шаардахгүй байвал зохилтой. Мөн тэднийг агуулгыг авч хаях үндэслэлгүй буюу хуулиас гадуур дүрмийн субъект үл болгохыг зөвлөж байна.
20. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эздийн нэрийг ил болгох зохицуулалтыг хэвлэл мэдээллийн эрх зүйн орчинд бий болгох, цаашлаад хэвлэл мэдээллийн хэрэгслийн эздийг редакцын хараат бус байдлыг баталгаажуулахын тулд редакцын албаныхантай гэрээ байгуулах үүргийг оноосон заалтыг хэвлэл мэдээллийн тухай хууль тогтоомжинд тусгах.
21. Хуулийн зохицуулалтаар хариуцлагыг дамжуулсан мэдээллийн хэрэгсэл биш харин улс төрийн сурталчилгаа буюу уриа бичлэг гаргасан улс төрч холбоотой хүлээлгэх зохицуулалтыг хуулинд тусгах.

ИРГЭН БОЛОН ОЛОН УЛСЫН АЖИГЛАГЧИД

22. Дотоодын болон гадаадын ажиглагчдыг сонгуулийн явцыг бүхэлд ажиглах боломжоор хангах зохицуулалтыг сонгуулийн хууль тогтоомжинд тусгах. Сонгуулийн өмнө болон санал авах өдөр ажиглалт хийх эрх олгох тухай салангид журам болон дуусах хугацааны асуудлыг авч үзэх нь зүйтэй. Түүнчлэн сонгууль болохоос өмнө тодорхой цаг хугацаа хүртэл сонгуулийн ажиглалт хийх эрх олгох.

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ

23. Сонгуулийн үйл явцад итгэх олон нийтийн итгэлийг хадгалах, ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд сонгогчдоос ирсэн өргөдөл, гомдол, түүнчлэн гомдлын мөрөөр

хийсэн шалгалт, шийдвэрийн дэлгэрэнгүйтэй танилцах боломжоор олон нийтийг хангах талын арга хэмжээг авах.

САНАЛ АВАХ ӨДӨР

24. Санал өгөх цаг эхлэхээс өмнө санал хураах өдөрт зориулан хийсэн эцсийн бэлтгэлийг СХХ-д дүгнэх боломж олгох зохицуулалтыг МУЕСХ-д нэмэлт өөрчлөлтөөр оруулах.
25. Саналын хуудас, түүнчлэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах үеийн нууцлалыг хамгаалах нэмэлт арга хэмжээ авах, СХХ-нуудад зориулсан нэмэлт сургалт, заавар, түүнчлэн сонгогчдын боловсролыг нэмэгдүүлэх.
26. СЕХ болон эрх бүхий бусад холбогдох байгууллагууд санал авах байрнуудад хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын нэвтрэх боломжийг хөнгөвчлөхийн тулд шаардлагатай арга хэмжээг тогтоох, батлах, үүний дотор шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль тогтоомжинд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор дахин нягталж үзэх. Энэ ажилд хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын оролцуулах.

ХАВСРАЛТ – СОНГУУЛИЙН ҮР ДҮН

№	Аймаг, дүүрэг	Жагсаалтад бичигдсэн	Санал өгсөн	Санал өгсөн, %	Хүчингүй	Хүчингүй саналын хуудасны %	Хүчинтэй саналын хуудасны тоо	Хүчинтэй саналын хуудасны, %	Ц. Элбэгдорж	Ц. Элбэгдорж, %	Б. Бат-Эрдэнэ	Б. Бат-Эрдэнэ, %	Н. Удвал	Н. Удвал, %	Тэмдэглэгүй	Тэмдэглэгүй, %
1	Архангай	58319	35553	60.96	0	0	35553	100	15688	44.13	14535	40.88	4615	12.98	596	1.68
2	Баян-Өлгий	55456	35320	63.69	0	0	35320	100	18839	53.34	13297	37.65	2240	6.34	766	2.17
3	Баянхонгор	52032	33354	64.1	0	0	33354	100	16134	48.37	14725	44.15	1986	5.95	396	1.19
4	Булган	38734	25036	64.64	0	0	25036	100	10023	40.03	12075	48.23	2577	10.29	330	1.32
5	Говь-Алтай	34616	23411	67.63	0	0	23411	100	9731	41.57	11218	47.92	2199	9.39	223	0.95
6	Говьсүмбэр	9543	6317	66.2	0	0	6317	100	2664	42.17	3111	49.25	436	6.9	95	1.5
7	Дорноговь	39832	26003	65.28	0	0	26003	100	9842	37.85	13880	53.38	1866	7.18	377	1.45
8	Дорнод	49942	30337	60.74	0	0	30337	100	16098	53.06	11798	38.89	1886	6.22	463	1.53
9	Дундговь	27776	17571	63.26	0	0	17571	100	6401	36.43	9455	53.81	1524	8.67	164	0.93
10	Завхан	44719	31541	70.53	0	0	31541	100	15530	49.24	14728	46.69	960	3.04	278	0.88
11	Өвөрхангай	71584	45564	63.65	0	0	45564	100	21012	46.12	20808	45.67	2876	6.31	684	1.5
12	Өмнөговь	38264	25045	65.45	0	0	25045	100	11502	45.93	11181	44.64	2179	8.7	158	0.63
13	Сүхбаатар	37234	26000	69.83	0	0	26000	100	10290	39.58	14168	54.49	962	3.7	480	1.85
14	Сэлэнгэ	69785	43220	61.93	0	0	43220	100	20377	47.15	17900	41.42	4233	9.79	608	1.41
15	Төв	59650	37699	63.2	0	0	37699	100	14848	39.39	19165	50.84	2971	7.88	620	1.64
16	Увс	47659	33356	69.99	0	0	33356	100	15402	46.17	15299	45.87	2066	6.19	454	1.36
17	Ховд	48864	32929	67.39	0	0	32929	100	20144	61.17	10562	32.08	1765	5.36	376	1.14
18	Хөвсгөл	80561	51755	64.24	0	0	51755	100	27056	52.28	20827	40.24	3106	6	642	1.24
19	Хэнтий	45752	30430	66.51	0	0	30430	100	10156	33.37	19019	62.5	776	2.55	411	1.35
20	Дархан-Уул	64256	40932	63.7	0	0	40932	100	20474	50.02	17248	42.14	2785	6.8	372	0.91
21	Орхон	66308	42883	64.67	0	0	42883	100	22084	51.5	16274	37.95	4092	9.54	382	0.89
	Аймгуудийн дүн	1040886	674256	64.78	0	0	674256	100	314295	46.61	301273	44.68	48100	7.13	8875	1.32
22	Баянгол дүүрэг	123481	87424	70.8	0	0	87424	100	49903	57.08	32158	36.78	4702	5.38	570	0.65
23	Баянзүрх	190606	128637	67.49	0	0	128637	100	70763	55.01	49777	38.7	6822	5.3	1120	0.87

	дүүрэг															
24	Сүхбаатар дүүрэг	87567	60764	69.39	0	0	60764	100	33366	54.91	23681	38.97	3157	5.2	484	0.8
25	Сонгино хайрхан дүүрэг	183372	124790	68.05	0	0	124790	100	67209	53.86	48343	38.74	8079	6.47	1042	0.84
26	Хан-Уул дүүрэг	83814	58764	70.11	0	0	58764	100	31870	54.23	22883	38.94	3413	5.81	530	0.9
27	Чингэлтэй дүүрэг	105475	71869	68.14	0	0	71869	100	38614	53.73	28130	39.14	4318	6.01	729	1.01
28	Налайх	21864	15106	69.09	0	0	15106	100	7559	50.04	6078	40.24	1262	8.35	175	1.16
29	Багануур дүүрэг	18493	12177	65.85	0	0	12177	100	5685	46.69	5880	48.29	475	3.9	121	0.99
30	Багахангай	2482	1755	70.71	0	0	1755	100	791	45.07	894	50.94	53	3.02	14	0.8
Нийслэлийн дүн		817154	561286	68.69	0	0	561286	100	305760	54.47	217824	38.81	32281	5.75	4785	0.85
Гадаадад байгаа		6233	4242	68.06	0	0	4242	100	2739	64.57	1283	30.25	182	4.29	28	0.66
НИЙТ ДҮН		1864273	1239784	66.5	0	0	1239784	100	622794	50.23	520380	41.97	80563	6.5	13688	1.1

Эх сурвалж: Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо (www.gec.gov.mn)

ЕАБХАБ-ЫН АИХЭГ-ЫН ТУХАЙ

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын үндсэн институт болох Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар (ЕАБХАБ-ын АИХЭГ) нь өөрийн бүрэн эрхт гишүүн орнуудад “хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн хүндэтгэх байдлыг хангах, хууль дээдлэх ёсыг сахих, ардчлалын зарчмыг болон (...) хөхиүлэн дэмжих, ардчлалын институцуудыг байгуулах, бэхжүүлэх, хамгаалах, түүнчлэн нийгмийг бүхэлдээ бие биедээ хүндэтгэлтэй хандах хандлагыг хөхиүлэн дэмжих”-д нь туслалцаа үзүүлэх зорилготой (1992 оны Хельсинкийн Дээд хэмжээний уулзалтын баримт бичиг). Энэ нь ЕАБХАБ-ын хүний хэмжүүр гэж тооцогдоно.

Польш Улсын Варшав хотод байдаг ЕАБХАБ-ын АИХЭГ нь 1990 оны Парисын Дээд хэмжээний уулзалтын үеэр Чөлөөт сонгуулийн төлөө газар нэртэйгээр үүсгэн байгуулагдсан ба 1991 оны 5-р сараас үйл ажиллагаагаа эхэлжээ. Тус байгууллагын эрх нь хүний эрх, ардчилалтай холбоотой асуудлаар өргөжисөн тул нэг жилийн дараа уг байгууллагын нэрийг өөрчилсөн. Өнөөдөр тус байгууллагад 130 гаруй ажилтан ажиллаж байна.

ЕАБХАБ-ын АИХЭГ нь **сонгуулийн ажиглалт явуулах** чиглэлээр Европод тэргүүлдэг болно. ЕАБХАБ-ын бүс нутагт явагдаж байгаа сонгуулиуд ЕАБХАБ-ын үүрэг амлалт, ардчилсан сонгуулийн төлөөх олон улсын бусад стандарт болон үндэсний хууль тогтоожийг даган мөрдөж байгаа эсэхэд үнэлгээ өгөх мянга мянган ажиглагчдыг томилох ажлыг жил бүр зохицуулдаг мөн зохион байгуулдаг. Энэ байгууллагын өвөрмөц аргачлал нь сонгуулийн үйл явцад бүрэн ажиглалт хийх боломж олгодог. ЕАБХАБ-ын АИХЭГ нь туслалцааны төслүүдээр дамжуулан бүрэн эрхт гишүүн орнуудынхаа сонгуулийн тогтолцоог сайжруулахаар хийж байгаа үйл ажиллагаанд нь тусалдаг.

ЕАБХАБ-ын АИХЭГ-ын **ардчлалын** үйл ажиллагаанд хууль дээдлэх ёс, хууль цаазын дэмжлэг, ардчилсан засаглал, шилжилт хөдөлгөөн, шилжин суух эрх чөлөө, жендэрийн тэгш байдал багтана. Тус байгууллага нь ардчилсан бүтцийг хөгжүүлэхийг эрэлхийлэн жил бүр тусламжийн зорилтод хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг.

Түүнчлэн бүрэн эрхт орнуудаа ЕАБХАБ-ын хүний эрх, ардчилалтай холбоотой цогц норм, үйл ажиллагааны үүрэг амлалтын дагуу **хүний эрх**, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах үүргээ биелүүлэхэд нь тусалдаг. Ингэхийн тулд хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, тухайлсан буюу сэдэвчилсэн чиглэлээр, үүний дотор терроризмтэй тэмцэх явцад хөндөгдөх хүний эрх, хүний наймааны гэмт хэргийн хохирогчдын хүний эрхийн хамгаалалтыг нэмэгдүүлэх, хүний эрхийн боловсрол, сургалт, хүний эрхийн мониторинг ба тайлан гаргах, болон эмэгтэйчүүдийн хүний эрх, аюулгүй байдлын талаарх чадавхийг бэхжүүлэх, мэдлэг туршлагаа хуваалцах чиглэлээр янз бүрийн түншүүдтэй хамтран ажилласны үрээр амжилт гаргаж байна.

ЕАБХАБ-ын АИХЭГ нь **бусдад хүндэтгэлтэй хандах, үл ялгаварлан гадуурхах** чиглэлийн хүрээнд бүрэн эрхт гишүүн орнууд нь гэмт хэргийг үзэн ядах, арьсны үзлийн зөрчил, гадаадынхныг үзэн ядах үзэл, семитийн эсрэг үзэл, болон бусад хэлбэрийн үл хүндэтгэлүүдэд хариу арга хэмжээ авах чадвараа бэхжүүлэхэд нь тусладаг. ЕАБХАБ-ын АИХЭГ-ын бусдад хүндэтгэлтэй хандах, үл ялгаварлан гадуурхалтай холбоотой үйл ажиллагаа нь дараахь чиглэлд анхаардаг: үүнд хууль тогтоомж; хуулийг биелүүлэх тухай сургалт; үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчилд өгсөн хариу арга хэмжээг хянах, тайлагнах, нягтлах; түүнчлэн бусдад хүндэтгэлтэй хандах, хүндэтгэх болон хамтын ойлголцлыг хөхиүлэн дэмжисэн боловсролын үйл ажиллагаа багтана.

ЕАБХАБ-ын АИХЭГ нь бүрэн эрх гишүүн орнуудынхаа Ромачууд болон Синтичуудад (**Roma and Sinti**) талаарх бодлогод нь зөвлөгөө өгдөг. Мөн тэднийг чадавхжуулах, сүлжээ үүсгэх асуудлыг хөхиүлэн дэмжихийн зэрэгцээ бодлого боловсруулах түвшинд тэдний төлөөллийг оруулцуулахыг дэмждэг.

АИХЭГ-ын бүх үйл ажиллагааг ЕАБХАБ-ын бүрэн эрхт орнууд, ЕАБХАБ-ын институудууд болон түүний чиглэл хариуцсан байгууллагууд, түүнчлэн олон улсын бусад байгууллагуудын нягт хамтын ажиллагаа, уялдаатайгаар хэрэгжүүлдэг. Дэлгэрэнгүй мэдээллийг АИХЭГ-ын www.osce.org/odihr цахим хуудаснаас үзнэ үү.